# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2026 оны 08 дугаар сарын 07
№29 (1424)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

# ГАРЧИГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


| | | |
|---|---|---|
| 169. | Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 1577 |
| 170. | Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай | 1591 |
| 171. | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 1593 |
| 172. | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай | 1608 |
| 173. | Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | 1610 |
| 174. | Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай | 1614 |
| 175. | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 1616 |
| 176. | Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 1620 |
| 177. | Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн  тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай | 1626 |
| 178. | Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 1628 |

| | | | |
|---|---|---|---|
| 179. | Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай | | 1629 |
| 180. | Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай | | 1631 |
| 181. | Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай | | 1632 |
| 182. | Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай | | 1633 |
| 183. | Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай | | 1634 |


## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 184. | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 25 | 1635 |
| 185. | Засгийн газарт чиглэл өгөх тухай | Дугаар 52 | 1684 |
| 186. | Засгийн газарт чиглэл өгөх тухай | Дугаар 53 | 1686 |

[illegible]

[illegible]

| | | |
|---|---|---|
| ᠑᠒᠖᠂ | [illegible] | ᠑᠗᠒᠒ |
| ᠑᠒᠐᠂ | [illegible] | ᠑᠗᠓᠑ |
| ᠑᠒᠑᠂ | [illegible] | ᠑᠗᠓᠓ |
| ᠑᠒᠓᠂ | [illegible] | ᠑᠖᠐᠗ |
| ᠑᠒᠓᠂ | [illegible] | ᠑᠖᠖᠐ |
| ᠑᠒᠑᠂ | [illegible] | ᠑᠖᠖᠑ |
| ᠑᠒᠗᠂ | [illegible] | ᠑᠖᠖᠖ |
| ᠑᠒᠖᠂ | [illegible] | ᠑᠖᠘᠐ |

| | | | |
|---|---|---|---|
| ᠑᠗᠗· | [illegible] | | ᠑᠖᠓᠖ |
| ᠑᠗᠘· | [illegible] | | ᠑᠖᠓᠘ |
| ᠑᠗᠙· | [illegible] | | ᠑᠖᠓᠙ |
| ᠑᠘᠐· | [illegible] | | ᠑᠖᠓᠑ |
| ᠑᠘᠑· | [illegible] | | ᠑᠖᠓᠒ |
| ᠑᠘᠒· | [illegible] | | ᠑᠖᠓᠓ |
| ᠑᠘᠓· | [illegible] | | ᠑᠖᠓᠔ |
| ᠑᠘᠔· | [illegible] | [illegible] ᠒᠕ | ᠑᠖᠓᠕ |
| | [illegible] | | |
| ᠑᠘᠕· | [illegible] | [illegible] ᠕᠒ | ᠑᠖᠘᠔ |
| ᠑᠘᠖· | [illegible] | [illegible] ᠕᠓ | ᠑᠖᠘᠖ |

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын ерөнхий хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/4 дүгээр зүйлийн 4.1.20 дахь заалт:**

“4.1.20.“тэтгэврийн мөнгөн хуримтлал” гэж даатгуулагчийн төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 1 хувьтай тэнцэх хөрөнгө, улсын төсвөөс олгосон урамшуулал болон хөрөнгө оруулалтын өгөөжөөс бүрдсэн мөнгөн хөрөнгийг.”

**2/7 дугаар зүйлийн 7.11-7.15 дахь хэсэг:**

“7.11.Энэ хуулийн 7.4.10-т заасан ажилтан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээний дагуу ажиллаж байгаа бол өөрт таатай нөхцөлтэй нэг гэрээнээс нийгмийн даатгалд албан журмаар даатгуулна.

7.12.Энэ хуулийн 7.2.1-д заасан даатгуулагч ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажилласан бол энэ хуулийн 7.4-т заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.

7.13.Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийн, их сургууль, коллежид дэд бакалаврын болон бакалаврын хөтөлбөрийн 15-24 насны суралцагч өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.4-т зааснаас бусад нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.

7.14.Даатгуулагч энэ хуулийн 7.13-т заасны дагуу төлөөгүй тэтгэврийн даатгалын шимтгэлээ 26 насанд хүрэхээс өмнө өөрөө хариуцан нөхөн төлж болно.

7.15.Энэ хуулийн 7.13-т заасан даатгуулагч шимтгэл нөхөн төлөх хүсэлт гаргасан тохиолдолд шимтгэл төлөх хугацаа, хэмжээг нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээгээр тохирно.”

**3/13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалт:**

“13.1.5.тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгийг энэ хуулийн 29.7-д заасан хөрөнгө оруулалтын бодлогод тусгагдсан санхүүгийн хэрэгсэлд.”

**4/19 дүгээр зүйлийн 19.5-19.7 дахь хэсэг:**

“19.5.Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2028 онд 12 дахин, 2029 онд 11 дахин, 2030 он ба түүнээс хойш 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.

19.6.Энэ хуулийн 7.4.10-т заасан гэрээ байгуулсан ажил олгогчийн сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөх цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.

19.7.Энэ хуулийн 7.14-т заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доошгүй орлогоос сайн дураар даатгуулагчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр тооцон төлүүлнэ.”

**5/21 дүгээр зүйлийн 21.29-21.32 дахь хэсэг, тайлбар:**

“21.29.Сүүлийн таван жилийн дотор нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлсэн таваас ихгүй ажилтантай ажил олгогчийн гурав хүртэл ажилтны ажил олгогчийн төлөх энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан нийгмийн даатгалын шимтгэлээс 36 сар хүртэлх хугацаанд, хэрэв ажилтан хөгжлийн бэрхшээлтэй бол 60 сар хүртэлх хугацаанд чөлөөлж болно. Хэрэв ажил олгогч 5 ажилтантай бол 3 ажилтны, 4 ажилтантай бол 2 ажилтны, 2 ба 3 ажилтантай бол 1 ажилтны ажил олгогчийн төлөх шимтгэлээс чөлөөлөгдөнө. Энэ шимтгэлийн чөлөөлөлтөд даатгуулагч зөвхөн нэг удаа хамрагдана.

Тайлбар: Сүүлийн таван жил гэдгийг ажил олгогч шимтгэлээс чөлөөлөгдөх хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад гаргасан сараас өмнөх 60 сарыг ойлгоно.

21.30.Энэ хуулийн 21.29-д заасан ажил олгогчид төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээд, гадаад улсын, олон улсын байгууллага болон төрийн бус байгууллага хамаарахгүй.

21.31.Энэ хуулийн 21.29-д заасан нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх хүсэлтийг ажил олгогч нийгмийн даатгалын байгууллагад гаргана.

21.32.Нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар даатгуулж байгаагүй Монгол Улсын иргэн анх удаа энэ хуулийн 7.7-д заасны дагуу даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг чөлөөлнө. Чөлөөлөх хугацаа 24 сараас ихгүй байна.”

**6/23 дугаар зүйлийн 23.1.8 дахь заалт:**

“23.1.8.энэ хуулийн 21.29-д зааснаар ажил олгогчийн шимтгэлээс чөлөөлөгдсөн хугацаа.”

**7/24 дүгээр зүйлийн 24.1.7 дахь заалт:**

“24.1.7.энэ хуулийн 7.13-т заасны дагуу даатгуулсан бол.”

**8/30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэг:**

“30.2.Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бүртгэх, төлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журам, хэрэглэх маягтын загварыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.”

**2 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.10.1 дэх заалтын “санхүүгийн” гэсний дараа “, эрүүл мэндийн магадлалын” гэж, 38.10.2 дахь заалтын “олгох,” гэсний дараа “хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний, амаржсаны эмнэлгийн хуудасны бичилт, олголтын үндэслэл,” гэж, 38.10.4 дэх заалтын “шимтгэлийн өрийг” гэсний дараа “бүрэн төлж дуусах хүртэлх хугацаанд” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэг:**

“7.6.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн энэ хуулийн 7.3.4-т заасан тэтгэвэр авагч

болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон иргэн өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.”

**2/12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг:**

“12.3.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сангийн төвлөрсөн орлогын харилцах дансанд орсон энэ хуулийн 11.1.1, 11.1.2, 11.1.5, 11.1.7-д заасан орлогыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төвлөрсөн харилцах дансанд төвлөрүүлнэ.”

**3/19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэг:**

“19.4.Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх, даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг доор дурдсанаар тогтооно:

19.4.1.энэ хуулийн 7.4.10-т зааснаас бусад албан журмаар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар;

19.4.2.энэ хуулийн 7.4.10-т заасан даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар;

19.4.3.сайн дураар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар.”

**4/27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь хэсэг:**

“27.1.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага даатгуулагчийн ажил олгогчоос болон өөрөө хариуцан төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийг даатгуулагч бүрээр сар бүр бүртгэж, төсвийн жилийн эцэст төлсөн шимтгэлийн нийт дүнг дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан гаргана.

27.2.Энэ хуулийн 27.1-д заасан бүртгэлийг даатгуулагчид мэдээлэл өгөх, тэтгэврийн даатгалын сангийн судалгаа, шинжилгээ, актуар тооцоолол хийх зорилгоор ашиглана.”

**5/29 дүгээр зүйл:**

**“29 дүгээр зүйл.Тэтгэврийн мөнгөн хуримтлал бүрдүүлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх**

29.1.Даатгуулагч тэтгэврийн мөнгөн хуримтлал бүрдүүлэх зорилгоор өөрөө хүсвэл энэ хуулийн 18.1, 18.3-т заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний даатгуулагчийн 1.0 хувийн шимтгэлийн орлогыг хуримтлуулж болно. Тэтгэврийн мөнгөн хуримтлалыг даатгуулагч өндөр насны тэтгэвэр тогтоолгохоос тавaас доошгүй жилийн өмнө үүсгэнэ.

29.2.Даатгуулагч энэ хуулийн 29.1-д заасан тэтгэврийн мөнгөн хуримтлал үүсгэх хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад цахимаар, эсхүл биечлэн, хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүн бол асран хамгаалагчийн дэмжлэгтэйгээр гаргана.

29.3.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгийг Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан арилжааны банканд төвлөрсөн данс нээж байршуулна.

29.4.Даатгуулагчийн тухайн жилийн тэтгэврийн мөнгөн хуримтлалын 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг жилд нэг удаа төсвийн жилийн нэгдүгээр улиралд багтаан нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад улсын төсвөөс шилжүүлнэ. Улсын төсвөөс урамшууллыг хариуцан төлөх хугацаа 120 сараас ихгүй байна.

29.5.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 29.4-т заасан тэтгэврийн мөнгөн хуримтлалыг даатгуулагч бүрээр хуваарилж, бүртгэнэ.

29.6.Даатгуулагчийн тэтгэврийн мөнгөн хуримтлалыг энэ хуулийн 13.1-д заасан санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болно.

29.7.Даатгуулагчийн тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгө оруулалтын удирдлагыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрхлэх бөгөөд хөрөнгийн тодорхой хэсгийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 4.1.11-д заасан хөрөнгө оруулалтын менежментийн компани, мөн хуулийн 43.1-д заасны дагуу Монгол Улсад хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэхээр Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн гадаад улсад бүртгэлтэй хөрөнгө оруулалтын сан, түүний охин болон хараат компаниар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. Гэрээнд хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлсон байна.

29.8.Энэ хуулийн 29.7-д заасан үйл ажиллагааны зардлыг нийгмийн даатгалын байгууллага болон тэтгэврийн мөнгөн хуримтлал үүсгэж байгаа даатгуулагч хамтран хариуцна.

29.9.Даатгуулагч нас барвал түүний тэтгэврийн мөнгөн хуримтлалын зарцуулагдаагүй үлдэгдлийг хууль ёсны өв залгамжлагчид нь өвлүүлнэ.

29.10.Тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, эрх бүхий мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, өвлүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг санхүү, төсвийн, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооны саналыг үндэслэн Засгийн газар батална.”

**4 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “төрөл тус бүр нь” гэснийг “сан нь” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “үлдэгдлийг” гэснийг “үлдэгдэл болон энэ хуулийн 4.1.20-д заасан тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгийг” гэж, 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь хэсгийн, 37 дугаар зүйлийн 37.14.2 дахь заалтын “нийслэлийн” гэснийг “дүүргийн” гэж, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн хүснэгтийн “Ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/” гэсэн баганын “3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал” хэсгийн “0.5, 1.5, 2.5” гэснийг “0.3, 1.2, 2.2” гэж, “4.Ажилгүйдлийн даатгал” хэсгийн “0.5” гэснийг “0.6” гэж, “Шимтгэлийн дүн” хэсгийн “10.5, 11.5, 12.5” гэснийг “10.4, 11.3, 12.3” гэж, 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсгийн “журмыг” гэснийг “журам, энэ хуулийн 7.15-д заасан гэрээний загварыг” гэж, 21 дүгээр зүйлийн “21.29, 21.30” дахь хэсгийн дугаарыг “21.33, 21.34” гэж, 27 дугаар зүйлийн гарчгийн “**Тэтгэврийн даатгалын нэрийн дансны бүртгэл**” гэснийг “**Тэтгэврийн даатгалын шимтгэлийн бүртгэл**” гэж, 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсгийн “3-аас доошгүй” гэснийг “2-оос доошгүй” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.4 дэх заалтын “хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “үнэ тогтоох,” гэснийг, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн, мөн зүйлийн 37.5 дахь хэсгийн, мөн зүйлийн 37.6 дахь хэсгийн, мөн зүйлийн 37.8 дахь хэсгийн, 38 дугаар зүйлийн 38.5 дахь хэсгийн, 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийн “нийслэл,” гэснийг, 37.3 дахь

хэсгийн “Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг,” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.15 дахь заалтыг, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтыг, 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.5 дахь заалтыг, 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтыг, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийг, 21 дүгээр зүйлийн 21.31 дэх хэсгийг, 27 дугаар зүйлийн 27.3, 27.4, 27.5, 27.6, 27.7, 27.8, 27.9, 27.10 дахь хэсгийг, 28 дугаар зүйлийг, 37 дугаар зүйлийн 37.9, 37.11, 37.12 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.**Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтаар нэмсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**8 дугаар зүйл.**Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ**

ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠴᠠᠭᠠᠵᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ

2026 ᠣᠨ ᠤ 1 ᠳᠦᠭᠡᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ 28 — ᠨᠤ ᠡᠳᠦᠷ

ᠨᠡᠶᠢᠰᠯᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ.
ᠬᠠᠮᠲᠤᠷᠠᠨ ᠠᠵᠢᠯᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

1. ᠳᠣᠣᠷᠠᠬᠢ ᠬᠤᠷᠠᠯ: ᠨᠡᠶᠢᠰᠯᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠪᠣᠳᠣᠯᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠨᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠬᠤ ᠨᠢ:

1/ ᠳᠣᠣᠷᠠᠬᠢ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ 2019.9.10 ᠤ ᠡᠳᠦᠷ ᠦᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ:

ᠬᠣᠷᠢᠶᠠᠨ ᠤ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠪᠣᠳᠣᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ «ᠨᠡᠶᠢᠰᠯᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ» ᠬᠡᠮᠡᠬᠦ ᠨᠡᠶᠢᠰᠯᠡᠯ ᠦᠨ ᠬᠠᠮᠲᠤ ᠶᠢᠨ «2019.9.10» ᠤ ᠡᠳᠦᠷ ᠦᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠵᠢᠭᠠᠯᠲᠠ ᠪᠠ ᠬᠠᠮᠲᠤ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ ᠵᠢᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ..»

2/ ᠳᠣᠣᠷᠠᠬᠢ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ 2025.12.26 ᠤ ᠡᠳᠦᠷ ᠦᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ:

«2.1.10— ᠳᠤ ᠨᠡᠶᠢᠰᠯᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠳᠦ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠰᠢᠯᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠪᠠ ᠬᠠᠮᠲᠤ ᠶᠢᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠪᠣᠳᠣᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ ᠪᠠ ᠨᠠᠶᠢᠷᠠᠮᠳᠠᠯ ᠢ ᠬᠠᠩᠭᠠᠬᠤ ᠶᠢ ᠳᠡᠮᠵᠢᠬᠦ ᠨᠢ 2.10.10» ᠬᠡᠮᠡᠨ ᠨᠡᠮᠡᠬᠦ ᠪᠡᠷ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠪᠠ.

2.1.9 ᠳᠤ ᠨᠡᠶᠢᠰᠯᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ ᠢ 2.2.6— ᠳᠤ ᠨᠡᠶᠢᠰᠯᠡᠯ ᠦᠨ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠮᠲᠤ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠪᠠ ᠨᠠᠶᠢᠷᠠᠮᠳᠠᠯ ᠢ ᠳᠡᠮᠵᠢᠬᠦ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯ ᠳᠤ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠪᠠ.

2.3.16. ᠨᠡᠶᠢᠰᠯᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠪᠣᠳᠣᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠠᠮᠲᠤ ᠶᠢᠨ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠳᠦ ᠳᠡᠮᠵᠢᠯᠭᠡ ᠦᠵᠡᠭᠦᠯᠬᠦ. ᠨᠡᠶᠢᠰᠯᠡᠯ ᠦᠨ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠮᠲᠤ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠰᠢᠯᠵᠢᠭᠦᠯᠬᠦ, ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ. ᠨᠡᠶᠢᠰᠯᠡᠯ ᠦᠨ 2.3.16—2.3.17 ᠳᠤ ᠬᠠᠮᠲᠤ ᠶᠢᠨ ᠪᠣᠳᠣᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠨᠠᠶᠢᠷᠠᠮᠳᠠᠯ ᠢ ᠬᠠᠩᠭᠠᠬᠤ ᠪᠠ ᠨᠡᠶᠢᠰᠯᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯ ᠳᠤ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠪᠠ..

ᠨᠡᠶᠢᠰᠯᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ 2.3.16— ᠳᠤ ᠨᠡᠶᠢᠰᠯᠡᠯ ᠦᠨ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠮᠲᠤ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠰᠢᠯᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠪᠠ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠳᠡᠮᠵᠢᠬᠦ ᠳᠦ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠪᠠ..

[illegible]

᠓/᠑᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑᠓.᠑.᠒ ᠳᠡᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ:

[illegible]

᠔/᠑᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑᠔.᠒ – ᠑᠔.᠔ ᠳᠡᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ:

[illegible]

[illegible]

[illegible]

᠕/᠑᠕ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑᠕.᠑ – ᠑᠕.᠓ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ᠂ ᠲᠠᠢᠯᠪᠤᠷᠢ:

[illegible]

᠖/᠒᠒ ᠦᠨᠳᠦᠰᠦᠨ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠒᠐᠒᠒ ᠣᠨ ᠤ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ :

«᠒᠐᠒᠒ — ᠨᠤ ᠡᠳᠦᠷ ᠦᠨ ᠒᠐᠒᠐ — ᠳᠤ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ::»

᠒/᠒᠐ ᠦᠨᠳᠦᠰᠦᠨ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠒᠐᠒᠒ ᠣᠨ ᠤ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ :

«᠒᠐᠒᠒ — ᠨᠤ ᠡᠳᠦᠷ ᠦᠨ ᠒᠐᠒᠐ — ᠳᠤ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ::»

᠑/᠐᠓ ᠦᠨᠳᠦᠰᠦᠨ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠒᠐᠒᠓ ᠣᠨ ᠤ ᠵᠠᠷᠯᠢᠭ :

ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠂ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠂ ᠰᠢᠯᠭᠠᠨ ᠪᠠᠲᠤᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠪᠣᠯᠤᠨ ᠠᠶᠤᠯᠭᠦᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠯᠲᠡ ᠳᠦ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠲᠠᠯᠪᠢᠬᠤ ᠂ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢ ᠬᠠᠩᠭᠠᠬᠤ ᠂» ᠭᠡᠰᠡᠨ ᠂ ᠖᠂᠑᠐᠂᠔ ᠳᠡᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠳᠤ «ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ» ᠭᠡᠰᠡᠨ ᠦ ᠳᠠᠷᠠᠭ᠎ᠠ «ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠠ» ᠭᠡᠵᠦ ᠦᠭᠡ ᠨᠡᠮᠡᠭᠰᠡᠭᠡᠢ ᠄

᠓ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠄ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠡᠬᠢ ᠪᠣᠯᠬᠤ ᠶᠢᠨ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠰᠡᠭ ᠂ ᠵᠦᠢᠯ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠭᠰᠡᠨ ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠭᠦᠯᠳᠡᠷ ᠄

᠑/᠒ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠒᠂᠖ ᠳᠡᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠄

«᠒᠂᠖᠂ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠪᠦᠬᠦᠢ ᠢᠷᠭᠡᠨ ᠤ ᠠᠮᠢᠳᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠡᠷᠬᠡ ᠲᠡᠢ ᠢᠷᠭᠡᠨ ᠳᠦ ᠘᠂᠑᠂᠔ — ᠳᠦ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠵᠢᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠒᠂᠔᠂᠖ — ᠳᠤ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠂ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠒ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑ ᠳᠡᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠲᠦ ᠵᠠᠭᠠᠭᠰᠠᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠂ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠖᠂᠑᠂᠑ — ᠳᠦ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠲᠡᠢ ᠢᠷᠭᠡᠨ ᠳᠦ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠦᠷᠲᠡᠭᠡᠬᠦ ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ ᠄»

᠔/᠑᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑᠔᠂᠔ ᠳᠡᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠄

«᠑᠔᠂᠔᠂ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠂ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠲᠡᠢ ᠢᠷᠭᠡᠨ ᠦ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠠ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠲᠡᠢ ᠢᠷᠭᠡᠨ ᠦ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠑᠑᠂᠑᠂᠑᠂ ᠑᠑᠂᠑᠂᠔᠂ ᠑᠑᠂᠑᠂᠗᠂ ᠑᠑᠂᠑᠂᠒ — ᠳᠦ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠦᠷᠲᠡᠭᠡᠬᠦ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠦᠷᠲᠡᠭᠡᠨ᠎ᠡ ᠄»

᠔/᠑᠙ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑᠙᠂᠑ ᠳᠡᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠄

«᠑᠙᠂᠑᠂ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠲᠡᠢ ᠢᠷᠭᠡᠨ ᠦ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠂ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠂ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠨ᠎ᠠ ᠄»

᠑᠙᠂᠑᠂᠑᠂ ᠳᠠᠬᠢ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠒᠂᠑᠂᠑᠐ — ᠳᠦ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ ᠳᠦ ᠬᠦᠷᠲᠡᠭᠡᠬᠦ ᠳᠤ ᠡᠷᠬᠡ ᠲᠡᠢ ᠳᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭ ᠦᠨ ᠳᠦ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠠᠷ ᠠᠵᠢᠯᠯᠠᠬᠤ ᠳᠤ ᠑᠐ ᠬᠣᠨᠤᠭ ᠦᠨ ᠳᠣᠲᠣᠷ᠎ᠠ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠨ᠎ᠠ ᠄

᠑᠙᠂᠑᠂᠔᠂ ᠳᠠᠬᠢ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠒᠂᠑᠂᠑᠐ — ᠳᠦ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ ᠳᠦ ᠬᠦᠷᠲᠡᠭᠡᠬᠦ ᠳᠤ ᠡᠷᠬᠡ ᠲᠡᠢ ᠳᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭ ᠦᠨ ᠳᠦ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠠᠷ ᠠᠵᠢᠯᠯᠠᠬᠤ ᠳᠤ ᠖ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠳᠣᠲᠣᠷ᠎ᠠ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠨ᠎ᠠ ᠄

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 1 жилийн дотор тэтгэврийн мөнгөн хуримтлал үүсгэх хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад гаргасан даатгуулагчийн 2027 он хүртэл хуримтлуулсан тэтгэврийн нөөц сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тэтгэврийн мөнгөн хуримтлалын гарааны үлдэгдэл болгон хуваарилж бүртгэх ажлыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрхлэн гүйцэтгэнэ. Энэ хугацаанд хүсэлт гаргаагүй даатгуулагчийн тэтгэврийн нөөц сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тэтгэврийн даатгалын санд буцаан төвлөрүүлнэ.

**2 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын болон ажилгүйдлийн даатгалын сангийн төсвийг Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсөвт тусгана.

**3 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10 дахь хэсэгт заасан журам болон 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт заасан журам, маягтын загварыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө батална.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ**

## ᠶᠡᠷᠦᠩᠬᠡᠢ ᠰᠠᠶᠢᠳ ᠤᠨ ᠵᠠᠷᠯᠢᠭ

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠔ — ᠨᠦ ᠡᠳᠦᠷ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

[illegible]

᠑ [illegible]

᠒ [illegible]

᠓ [illegible]

ᠶᠡᠷᠦᠩᠬᠡᠢ ᠰᠠᠶᠢᠳ [illegible] ᠨ᠂ ᠤᠴᠢᠷᠠᠯ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр | Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

**1/2 дугаар зүйлийн 2.1.7-2.1.9 дэх заалт:**

“2.1.7.“өндөр насны тэтгэврийн ердийн нас” гэж тухайн даатгуулагчийн төрсөн онд харгалзах өндөр насны тэтгэврийн насыг;

2.1.8.“суурь тэтгэвэр” гэж энэ хуулийн дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр болон 10-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр авагч ахмад настанд авч байгаа тэтгэврийн хэмжээнээс нь хамааруулан тооцож улсын төсвөөс сар бүр олгох мөнгөн хөрөнгийг;

2.1.9.“хуримтлалын тэтгэвэр” гэж энэ хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон өндөр насны тэтгэвэр авагч, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид түүний тэтгэврийн мөнгөн хуримтлалаас сар бүр, эсхүл нэг удаа олгох мөнгөн хөрөнгийг.”

**2/5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсэг:**

“5.4.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч даатгуулагчийн өндөр насны тэтгэврийн эрх үүсэх, тэтгэвэр тогтоох харилцааг зөвхөн энэ хуулиар зохицуулна.

5.5.Энэ хуулийн 5.1.3-т заасан өндөр насны тэтгэврийн нас нь 1978 он ба түүнээс өмнө төрсөн даатгуулагчийн хувьд 50 нас, 1979 онд төрсөн даатгуулагчийн хувьд 50 нас 3 сар байна. Цаашид 1980 онд төрсөн даатгуулагчийн хувьд 50 нас 6 сар, 1981 онд төрсөн даатгуулагчийн хувьд 50 нас 9 сар байх бөгөөд тэтгэвэр тогтоолгох насыг даатгуулагчийн төрсөн онд харгалзуулан 3 сараар нэмэгдүүлж, 1998 он ба түүнээс хойш төрсөн даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийн нас 55 байна.”

**3/7 дугаар зүйлийн 7.7, 7.8 дахь хэсэг:**

“7.7.Энэ хуулийн 5.1.1, 5.1.2-т заасан шимтгэл төлсөн хугацааны нөхцөлийг хангасан даатгуулагч өндөр насны тэтгэврийн ердийн наснаас хойш тэтгэвэр тогтоолгох бол энэ хуулийн 8.8-д заасны дагуу бодсон тэтгэврийн хэмжээг дараах томьёог хэрэглэн нэг удаа нэмэгдүүлэн тогтооно:

$$Ө_К=1.04^{ттн-ен}$$

$Ө_К$ -өндөр насны тэтгэврийн ердийн наснаас хойш тогтоолгосон тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэн бодох коэффициент;

ттн -тэтгэвэр тогтоолгосон нас;
ен -өндөр насны тэтгэврийн ердийн нас.

7.8.Даатгуулагч энэ хуулийн 5.1.2-т заасан нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол энэ хуулийн 8.8-д заасны дагуу бодсон тэтгэврийн хэмжээг дараах томьёог хэрэглэн нэг удаа бууруулан тогтооно.

$$Б_К=0.96^{ен-ттн}$$

$Б_К$ -өндөр насны тэтгэврийн ердийн наснаас өмнө тогтоолгосон тэтгэврийн хэмжээг бууруулан бодох коэффициент;

ен -өндөр насны тэтгэврийн ердийн нас;
ттн -тэтгэвэр тогтоолгосон нас.”

**4/9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт:**

“9.1.3.нөхөр, эхнэр хоёулаа суурь тэтгэвэр авагч байх.”

**5/20 дугаар зүйлийн 20.5, 20.6 дахь хэсэг:**

“20.5.Энэ хуулийн 20.1-д заасан тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх дараалсан жил нь 2027, 2028 онд 5 жил, 2029 онд 6 жил, 2030 онд 7 жил, 2031 онд 8 жил, 2032 онд 9 жил байх бөгөөд 2033 он ба түүнээс хойш 10 жил байна.Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлохдоо 2027, 2028 онд даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 5 жилийн нийлбэрийг 60-д, 2029 онд 6 жилийн нийлбэрийг хэрэв 70 ба түүнээс доош сар төлсөн бол 70-д, 71 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2030 онд 7 жилийн нийлбэрийг хэрэв 80 ба түүнээс доош сар төлсөн бол 80-д, 81 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2031 онд 8 жилийн нийлбэрийг хэрэв 90 ба түүнээс доош сар төлсөн бол 90-д, 91 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн

сарын тоонд, 2032 онд 9 жилийн нийлбэрийг хэрэв 100 ба түүнээс доош сар төлсөн бол 100-д, 101 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2033 он ба түүнээс хойш 10 жилийн нийлбэрийг хэрэв 110 ба түүнээс доош сар төлсөн бол 110-т, 111 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд тус тус хуваана.

20.6.Энэ хуулийн 20.2-т заасан шимтгэл төлсөн жил нь 2027, 2028 онд 5 жилээс доош, 2029 онд 6 жилээс доош, 2030 онд 7 жилээс доош, 2031 онд 8 жилээс доош, 2032 онд 9 жилээс доош байх бөгөөд 2033 он ба түүнээс хойш 10 жилээс доош байна.Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлохдоо 2027, 2028 онд даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 5 жилийн нийлбэрийг шимтгэл төлсөн сарын тоонд, 2029 онд 6 жилийн нийлбэрийг хэрэв 60 ба түүнээс доош сар төлсөн бол 60-д, 61 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2030 онд 7 жилийн нийлбэрийг хэрэв 70 ба түүнээс доош сар төлсөн бол 70-д, 71 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2031 онд 8 жилийн нийлбэрийг хэрэв 80 ба түүнээс доош сар төлсөн бол 80-д, 81 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2032 онд 9 жилийн нийлбэрийг хэрэв 90 ба түүнээс доош сар төлсөн бол 90-д, 91 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд, 2033 он ба түүнээс хойш 10 жилийн нийлбэрийг хэрэв 100 ба түүнээс доош сар төлсөн бол 100-д, 101 ба түүнээс дээш сар төлсөн бол шимтгэл төлсөн сарын тоонд тус тус хуваана.”

**2 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын “төлсөн” гэсний дараа “өндөр насны тэтгэврийн ердийн насанд буюу” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “даатгуулагчийн” гэсний дараа “тэтгэвэр тогтоолгохын өмнөх” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйл:**

“**3 дугаар зүйл.Олон давхаргат тэтгэврийн тогтолцоо**

3.1.Олон давхаргат тэтгэврийн тогтолцоо нь дараах гурван давхаргаас бүрдэнэ:

3.1.1.суурь тэтгэвэр;
3.1.2.тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр;
3.1.3.хувийн нэмэлт тэтгэвэр.

3.2.Энэ хуулийн 3.1.1-д заасан суурь тэтгэврийн зардлыг улсын төсвөөс, 3.1.2-т заасан тэтгэврийн зардлыг тэтгэврийн даатгалын сан болон улсын төсвөөс санхүүжүүлнэ.

3.3.Энэ хуулийн 3.1.3-т заасан хувийн нэмэлт тэтгэврийн харилцааг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиар зохицуулна.

3.4.Суурь тэтгэврийг доор дурдсан насанд хүрсэн тэтгэвэр авагчид олгоно:

3.4.1.энэ хуулийн 5.1.1-д заасан нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн өндөр насны тэтгэвэр авагч;

3.4.2.энэ хуулийн 5.1.2, 5.1.3, 5.1.4, 5.1.5, 5.1.6, 5.1.7-д заасан нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон эрэгтэй 60 насанд хүрсэн, эмэгтэй 55 насанд хүрсэн өндөр насны тэтгэвэр авагч, мөн насанд хүрсэн хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч.”

3.5.Суурь тэтгэврийн хэмжээг бодоход дараах томьёог хэрэглэнэ:

$$\text{С}_{\text{т}} = \text{С}_{\text{үд}} + \text{maximum}(\text{Н}_{\text{тд}} + \frac{\text{Ш}_{\text{нх}}}{12} * \text{Ж}_{\text{шт}} - 0.05 * \text{Т}_{a}, 0)$$

$\text{С}_{\text{т}}$ -Суурь тэтгэвэр;
$\text{С}_{\text{үд}}$ -Суурь тэтгэврийн үндсэн дүн;
$\text{Н}_{\text{тд}}$ -Суурь тэтгэврийн нэмэгдлийн хэмжээг тооцоход баримтлах тогтмол дүн;
$\text{Ш}_{\text{нх}}$ -Шимтгэл төлсөн нийт хугацаа, сараар;
$\text{Ж}_{\text{шт}}$ -Шимтгэл төлсөн жил тутамд тооцох дүн;
$\text{Т}_{a}$ -Авч байгаа тэтгэврийн хэмжээ;
maximum -хамгийн их утга.

3.6.Суурь тэтгэврийн үндсэн дүн, суурь тэтгэврийн хэмжээг тооцоход баримтлах тогтмол дүн, шимтгэл төлсөн жил тутамд тооцох дүн, суурь тэтгэврийн дээд хэмжээг Засгийн газар тогтооно.”

**2/4 дүгээр зүйл:**

“**4 дүгээр зүйл.Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн төрөл**

4.1.Энэ хуулийн 3.1.2-т заасан тэтгэвэр дараах төрөлтэй байна:

4.1.1.өндөр насны;
4.1.2.хөдөлмөрийн чадвар алдсаны;
4.1.3.тэжээгчээ алдсаны.”

**3/6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг:**

“6.2.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4.1.20-д заасан тэтгэврийн мөнгөн хуримтлал үүсгэсэн даатгуулагчийн тэтгэврийг бодоход энэ хуулийн 6.1.2-т заасан аргыг хэрэглэнэ.”

**4/8 дугаар зүйл:**

“**8 дугаар зүйл.Хуримтлалын тэтгэврийг бодох**

8.1.Хуримтлалын тэтгэврийг энэ хуульд заасан нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29.1-д заасан тэтгэвэр авагч өөрөө хүсвэл доор дурдсаны дагуу олгоно:

8.1.1.нэг удаагийн тэтгэвэр;
8.1.2.хугацаат тэтгэвэр.

8.2.Тэтгэврийн мөнгөн хуримтлалын хэмжээ нь тэтгэвэр тогтоолгох үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлснээс бага бол энэ хуулийн 8.1.1-д заасан тэтгэврийг нэг удаа олгоно.

8.3.Тэтгэврийн мөнгөн хуримтлалын хэмжээ нь тэтгэвэр тогтоолгох үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлснээс их бол 36-аас 120 хүртэл сарын хугацаанд энэ хуулийн 8.1.2-т заасан хугацаат тэтгэврийг сар бүр олгоно.

8.4.Энэ хуулийн 8.3-т заасан тэтгэврийг бодоход дараах томьёог хэрэглэнэ:

$$\mathrm{T_x} = \frac{\mathrm{HC_{c2}}}{k}$$

$\mathrm{T_X}$ -сарын хуримтлалын тэтгэврийн хэмжээ;
$\mathrm{HC_{C2}}$-тэтгэврийн мөнгөн хуримтлалын эцсийн үлдэгдэл;
$k$ -тэтгэвэр авах хугацаа, сараар.

8.5.Энэ хуулийн 8.4-т заасны дагуу бодогдсон хуримтлалын тэтгэврийн хэмжээг тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгө оруулалтын өгөөжийн хувиар нэмэгдүүлэн жил бүр дахин тогтоож, дараа жилийн 07

дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлсэн хуримтлалын тэтгэврийг олгоно.

8.6.Хуримтлалын тэтгэвэр авагч нас барвал түүний тэтгэврийн мөнгөн хуримтлалын зарцуулагдаагүй үлдэгдлийг хууль ёсны өв залгамжлагчид нь өвлүүлнэ.

8.7.Хуримтлалын тэтгэврийг тогтоож, олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална.

8.8.Энэ хуулийн 7.1, 13.1, 13.2 дахь хэсэгт заасны дагуу бодсон тэтгэврийн хэмжээг дараах тохируулах коэффициентоор үржүүлж сарын тэтгэврийн хэмжээг тодорхойлно:

$$b = \left(1 - \frac{\text{МХ}_{\text{ст}}}{16 * \text{НШ}_{\text{ст}}}\right)$$

*b* - тэтгэврийн тохируулах коэффициент
$\text{МХ}_{\text{СТ}}$- тэтгэврийн мөнгөн хуримтлал бүрдүүлсэн сарын тоо;
$\text{НШ}_{\text{СТ}}$- нийт шимтгэл төлсөн сарын тоо.”

**4 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын “50” гэснийг “55” гэж, мөн зүйлийн 5.2 дахь хэсгийн, 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтын, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “энэ хуулийн 5.1.1-д заасан” гэснийг “өндөр насны тэтгэврийн ердийн” гэж, 5 дугаар зүйлийн “Тайлбар:” хэсгийн “Энэ хуулийн 5.1.1-д заасан өндөр насны тэтгэврийн” гэснийг “Даатгуулагчийн өндөр насны тэтгэврийн ердийн” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “нэрийн дансны” гэснийг “хуримтлалд үндэслэсэн” гэж, 9 дүгээр зүйлийн гарчгийн “**Өндөр насны**” гэснийг “**Суурь**” гэж, мөн зүйлийн 9.1 дэх хэсгийн “Энэ хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр авч байсан тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд доор дурдсан нөхцөлийг хангасан түүний нөхөр, эсхүл эхнэрийн өндөр насны тэтгэврийг нэмэгдүүлнэ:” гэснийг “Доор дурдсан нөхцөл хангасан суурь тэтгэвэр авагчийн нөхөр, эсхүл эхнэр нас барсан тохиолдолд эхнэр, эсхүл нөхрийн авч байгаа суурь тэтгэврийн хэмжээг 50 хувиар нэмэгдүүлэн олгоно:” гэж, мөн зүйлийн 9.1.2 дахь заалтын “20” гэснийг “15” гэж, мөн зүйлийн 9.3 дахь хэсгийн “9.2-т заасан” гэснийг “9.1-д заасан суурь” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “5” гэснийг “10” гэж, мөн хэсгийн “60” гэснийг “120” гэж, 20.2 дахь хэсгийн “5” гэснийг “10” гэж, мөн зүйлийн “20.5, 20.6, 20.7” дахь хэсгийн дугаарыг “20.7, 20.8, 20.9” гэж, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “Тэтгэвэр авагчийн” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг, 9 дүгээр зүйлийн 9.2, 9.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтаар нэмсэн 7 дугаар зүйлийн 7.7, 7.8 дахь хэсгийг 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**7 дугаар зүйл.**Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **С.БЯМБАЦОГТ**

# ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

[illegible] ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

[illegible]

[illegible]

$Б_к$ –

$$Б_к=0.96^{ен-ттн}$$

ен –

ттн –

$Ө_к$ –

$$Ө_к=1.04^{ттн-ен}$$

[illegible]

ТТН — [illegible]

ӨН — [illegible]

ᠬᠡᠰᠡᠭ ᠪᠡᠷ ᠨᠡᠮᠡᠭᠰᠦᠭᠡᠢ᠃
᠓.᠓.ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠲᠦ ᠓.᠑.᠓ – ᠲᠤ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ ᠬᠤᠪᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠭᠳᠡᠯ ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠬᠤ ᠳᠤ ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ᠢ ᠬᠤᠪᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠭᠳᠡᠯ ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠬᠤ ᠳᠤ ᠪᠣᠳᠠᠨ
ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠬᠤ ᠳᠤ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠨ ᠢ ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠬᠤ ᠳᠤ ᠪᠠᠭᠤᠷᠠᠭᠤᠯᠤᠨ ᠤ ᠵᠢᠭᠠᠨ ᠪᠣᠯᠤᠨ ᠬᠣᠷᠢᠭ ᠤ ᠪᠣᠳᠣᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠭᠠᠳᠠᠭᠤᠯᠤᠨ᠎ᠠ᠃
᠓.᠒.ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠲᠦ ᠓.᠑.᠑ – ᠲᠤ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ ᠵᠠᠰᠠᠭᠤᠯ ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠬᠤ ᠳᠤ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠨ ᠢ ᠬᠣᠷᠢᠭ ᠤ ᠪᠣᠳᠣᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ᠂ ᠓.᠑.᠒ – ᠲᠤ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ

᠓.᠑.᠓.ᠬᠤᠪᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠭᠳᠡᠯ ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠬᠤ᠃
᠓.᠑.᠒.ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠬᠤ ᠳᠤ ᠪᠠᠭᠤᠷᠠᠭᠤᠯᠤᠨ ᠤ ᠵᠢᠭᠠᠨ ᠶᠢᠨ ᠬᠣᠷᠢᠭᠯᠠᠬᠤ ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠬᠤ;
᠓.᠑.᠑.ᠵᠠᠰᠠᠭᠤᠯ ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠬᠤ;

᠓.᠑.ᠬᠣᠷᠢᠯ ᠪᠣᠳᠣᠯᠭᠠᠯᠠᠭᠠᠪᠤᠯ ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠬᠤ ᠳᠤ ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠭᠤᠯᠬᠤ ᠪᠡᠷ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠬᠤᠪᠢ ᠪᠣᠳᠣᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠪᠣᠯᠭᠠᠨ᠎ᠠ᠄

«᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ᠬᠣᠷᠢᠯ ᠪᠣᠳᠣᠯᠭᠠᠯᠠᠭᠠᠪᠤᠯ ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠬᠤ ᠳᠤ ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠭᠤᠯᠬᠤ»

᠑/᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠄

ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯ ᠲᠠᠢ ᠬᠣᠯᠪᠣᠭᠳᠠᠭᠰᠠᠨ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠯᠠᠭᠤᠯᠤᠭᠰᠠᠨ᠄
᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ᠨᠡᠮᠡᠭᠳᠡᠯ ᠤ ᠵᠠᠰᠠᠭᠤᠯ ᠤ ᠵᠢᠭᠠᠨ ᠶᠢᠨ ᠬᠣᠷᠢᠭᠯᠠᠬᠤ ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠬᠤ ᠳᠤ ᠪᠣᠳᠠᠨ ᠬᠡᠰᠡᠭ ᠲᠦ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠵᠦᠢᠯ᠂ ᠬᠢᠵᠠᠭᠠᠷ ᠤ ᠪᠣᠳᠣᠯᠭ᠎ᠠ
ᠬᠢᠵᠠᠭᠠᠷ ᠤ «ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠭᠤᠯᠬᠤ ᠶᠢᠨ» ᠭᠡᠰᠡᠨ ᠢ ᠪᠣᠳᠣᠯᠭ᠎ᠠ «ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠬᠤ ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠭᠤᠯᠬᠤ ᠶᠢᠨ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ» ᠭᠡᠵᠦ ᠥᠭᠡᠷ ᠥᠭᠡᠷ ᠨᠡᠮᠡᠭᠳᠡᠨ᠎ᠡ᠃
ᠵᠠᠰᠠᠭᠤᠯ ᠲᠦ «ᠪᠣᠳᠣᠯᠭᠠᠯ» ᠭᠡᠰᠡᠨ ᠢ ᠪᠣᠳᠣᠯᠭ᠎ᠠ «ᠬᠣᠷᠢᠯ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ ᠢ ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠬᠤ ᠳᠤ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠨ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ ᠲᠤ ᠪᠠᠢᠳᠠᠯ» ᠭᠡᠵᠦ᠂ ᠒᠐ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠤᠨ ᠒᠐.᠑ ᠲᠤᠭᠠᠢ
᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ᠨᠡᠮᠡᠭᠳᠡᠯ ᠤ ᠵᠠᠰᠠᠭᠤᠯ ᠤ ᠵᠢᠭᠠᠨ ᠶᠢᠨ ᠬᠣᠷᠢᠭᠯᠠᠬᠤ ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠬᠤ ᠳᠤ ᠪᠣᠳᠠᠨ ᠬᠡᠰᠡᠭ ᠲᠦ ᠕ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠤᠨ ᠕.᠑.᠑ ᠲᠤᠭᠠᠢ

ᠵᠢᠯ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠬᠦ ᠵᠢᠯᠡᠭᠦᠦ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠵᠢᠯ ᠳᠤ ᠪᠣᠯᠤᠨ ᠲᠤ ᠣᠨ ᠣᠨ ᠬᠤᠪᠢᠶᠠᠷᠢᠭᠤᠯ᠃»
ᠬᠦ ᠪᠠᠭᠠ ᠪᠡᠷ ᠬᠤᠪᠢ ᠑᠐ ᠳᠤ ᠤ ᠨᠡᠮᠡᠭᠳᠡᠯ ᠢ ᠬᠤᠪᠢ ᠑᠐᠐ ᠬᠦ ᠪᠠᠭᠠ ᠪᠡᠷ ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠭᠰᠠᠨ ᠵᠢᠯ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠬᠦ ᠑᠐᠐ – ᠲᠤ᠂ ᠑᠐᠑ ᠬᠦ ᠪᠠᠭᠠ ᠪᠡᠷ ᠪᠣᠳᠣᠨᠣ
ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠭᠰᠠᠨ ᠵᠢᠯ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠬᠦ ᠙᠐ – ᠲᠤ᠂ ᠙᠑ ᠬᠦ ᠪᠠᠭᠠ ᠪᠡᠷ ᠪᠣᠳᠣᠨᠣ ᠵᠢᠯ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠬᠦ ᠵᠢᠯᠡᠭᠦᠦ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠵᠢᠯ ᠳᠤ ᠪᠣᠯᠤᠨ ᠲᠤ᠂ ᠒᠐᠓᠓ ᠣᠨ
ᠪᠠᠭᠠ ᠪᠡᠷ ᠪᠣᠳᠣᠨᠣ ᠵᠢᠯ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠬᠦ ᠵᠢᠯᠡᠭᠦᠦ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠵᠢᠯ ᠳᠤ ᠪᠣᠯᠤᠨ ᠲᠤ᠂ ᠒᠐᠓᠓ ᠣᠨ ᠲᠤ ᠙ ᠳᠤ ᠤ ᠨᠡᠮᠡᠭᠳᠡᠯ ᠢ ᠬᠤᠪᠢ ᠙᠐ ᠬᠦ ᠪᠠᠭᠠ ᠪᠡᠷ
ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠵᠢᠯ ᠳᠤ ᠪᠣᠯᠤᠨ ᠲᠤ᠂ ᠒᠐᠓᠑ ᠣᠨ ᠲᠤ ᠘ ᠳᠤ ᠤ ᠨᠡᠮᠡᠭᠳᠡᠯ ᠢ ᠬᠤᠪᠢ ᠘᠐ ᠬᠦ ᠪᠠᠭᠠ ᠪᠡᠷ ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠭᠰᠠᠨ ᠵᠢᠯ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠬᠦ ᠘᠐ – ᠲᠤ᠂ ᠘᠑ ᠬᠦ
ᠨᠡᠮᠡᠭᠳᠡᠯ ᠢ ᠬᠤᠪᠢ ᠗᠐ ᠬᠦ ᠪᠠᠭᠠ ᠪᠡᠷ ᠪᠣᠳᠣᠭᠳᠠᠭᠰᠠᠨ ᠵᠢᠯ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠬᠦ ᠗᠐ – ᠲᠤ᠂ ᠗᠑ ᠬᠦ ᠪᠠᠭᠠ ᠪᠡᠷ ᠪᠣᠳᠣᠨᠣ ᠵᠢᠯ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠬᠦ ᠵᠢᠯᠡᠭᠦᠦ

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

maximum – [illegible]
$Т_a$ – [illegible]
$Ж_{шт}$ – [illegible]
$Ш_{нх}$ – [illegible]
$Н_{тд}$ – [illegible]
$С_{уд}$ – ᠨᠥᠭᠡᠴᠡ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠦᠯᠡᠳᠡᠭᠳᠡᠯ ᠳᠦᠩ;
$С_т$ – ᠨᠥᠭᠡᠴᠡ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ;

$$С_т = С_{уд} + maximum(Н_{тд} + \frac{Ш_{нх}}{12} * Ж_{шт} - 0.05 * Т_a, 0)$$

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

᠙.᠑.᠑.ᠶᠠᠮᠠᠷ ᠪᠠ ;

᠙.᠑.᠒.ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠬᠠᠭᠠᠴᠠ ᠪᠠ ;

᠙.᠑.᠔.ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠠ ᠬᠠᠭᠠᠴᠠ ᠪᠠ ᠄᠄»

᠔/᠖ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠤ ᠖.᠔ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠄

«᠖.᠔.ᠬᠦᠷᠢᠶ᠎ᠡ ᠶᠢᠨ ᠤ ᠬᠤᠷᠠᠯ ᠤ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠯ ᠳᠦ ᠵᠢᠯ ᠤᠨ ᠖.᠑.᠑᠐ – ᠳᠤ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠲᠤ ᠰᠠᠩ ᠬᠦᠷᠢᠶᠡᠯᠡᠩ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ
ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠲᠤ ᠵᠢᠯ ᠤᠨ ᠖.᠑.᠔ – ᠳᠤ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠬᠡᠰᠡᠭ ᠤᠨ ᠨᠡᠮᠡᠰᠦᠭᠡᠢ ᠄᠄»

᠑/᠖ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠄

«᠑ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠄᠄ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠬᠤᠷᠠᠯ

᠑.᠖.ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠵᠢᠯ ᠤᠨ ᠳᠤ ᠰᠠᠩ ᠬᠦᠷᠢᠶᠡᠯᠡᠩ ᠬᠦᠷᠭᠡᠬᠦ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠬᠤ ᠪᠠ ᠭᠠᠵᠠᠷ ᠂ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠵᠠᠰᠠᠭ
ᠶᠠᠮᠠᠷ ᠪᠠ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠬᠤᠷᠢᠶᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠦᠷᠢᠶ᠎ᠡ ᠶᠢᠨ ᠤ ᠬᠤᠷᠠᠯ ᠤ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠯ ᠳᠦ ᠵᠢᠯ ᠤᠨ ᠔᠖.᠑ – ᠳᠤ ᠰᠠᠩ ᠬᠦᠷᠢᠶᠡᠯᠡᠩ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠬᠤᠷᠢᠶᠠᠯᠠᠬᠤ ᠳᠦ
ᠪᠠᠶᠢᠭᠤᠯ ᠬᠤᠷᠠᠯ ᠬᠤᠷᠢᠶᠠᠯᠠᠯᠲᠠ ᠪᠠ ᠬᠤᠷᠢᠶᠠᠯ ᠨᠡᠮᠡᠰᠦᠭᠡᠢ ᠄

᠑.᠑.᠑.ᠨᠢᠭᠡᠳᠦᠭᠡᠷ ᠬᠡᠰᠡᠭ ᠲᠤ ᠭᠠᠵᠠᠷ ᠄
᠑.᠑.᠔.ᠬᠤᠷᠢᠶᠠᠯᠠᠯᠲᠠ ᠭᠠᠵᠠᠷ ᠄᠄

᠑.᠔.ᠭᠠᠵᠠᠷ ᠲᠤ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠯ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠳᠤ ᠵᠠᠰᠠᠭ ᠬᠢ ᠭᠠᠵᠠᠷ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯᠲᠠ ᠬᠤᠷᠢᠶᠠ ᠳᠤ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠯ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠳᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠲᠤ ᠵᠢᠯ
ᠪᠠᠶᠢᠭᠤᠯ ᠤ ᠬᠤᠷᠢᠶᠠᠯ ᠬᠡᠰᠡᠭ ᠲᠤ ᠶ ᠭᠠᠵᠠᠷ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠬᠦᠷᠢᠶ᠎ᠡ ᠵᠢᠯ ᠤᠨ ᠑.᠑.᠑ – ᠳᠤ ᠰᠠᠩ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠲᠤ ᠬᠡᠰᠡᠭ ᠬᠡᠰᠡᠭ ᠬᠤᠷᠢᠶᠠᠯ ᠄᠄

᠑.᠔.ᠭᠠᠵᠠᠷ ᠲᠤ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠯ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠳᠤ ᠵᠠᠰᠠᠭ ᠬᠢ ᠭᠠᠵᠠᠷ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯᠲᠠ ᠬᠤᠷᠢᠶᠠ ᠳᠤ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠯ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠳᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠲᠤ ᠵᠢᠯ
ᠪᠠᠶᠢᠭᠤᠯ ᠤ ᠬᠤᠷᠢᠶᠠᠯ ᠬᠡᠰᠡᠭ ᠲᠤ ᠶ ᠭᠠᠵᠠᠷ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠬᠦᠷᠢᠶ᠎ᠡ ᠵᠢᠯ ᠤᠨ ᠔᠖ – ᠵᠢᠯ ᠑᠖᠐ ᠬᠤᠷᠢᠶᠠᠯ ᠬᠡᠰᠡᠭ ᠲᠤ ᠬᠤᠷᠢᠶᠠᠯᠠᠯᠲᠠ ᠳᠤ ᠵᠢᠯ ᠤᠨ ᠲᠤ
᠑.᠑.᠔ – ᠳᠤ ᠰᠠᠩ ᠬᠤᠷᠢᠶᠠᠯᠠᠯᠲᠠ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠬᠡᠰᠡᠭ ᠬᠤᠷᠢᠶᠠᠯ ᠄᠄

᠑.᠖.ᠵᠢᠯ ᠤᠨ ᠲᠤ ᠑.᠔ – ᠳᠤ ᠰᠠᠩ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠬᠤᠷᠠᠯ ᠳᠤ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠯ ᠬᠡᠰᠡᠭ ᠤᠨ ᠨᠡᠮᠡᠰᠦᠭᠡᠢ ᠄

$$T_x = \frac{HC_{c2}}{k}$$

$T_x$ – [illegible];
$HC_{C2}$ – [illegible];
$k$ – [illegible] ::

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

$$b = \left(1 - \frac{MX_{ст}}{16 * НШ_{ст}}\right)$$

$b$ – [illegible]
$MX_{СТ}$ – [illegible];
$НШ_{СТ}$ – [illegible] ::»

[illegible]

᠖.᠑.᠖ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ «ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠖.᠑.᠖ – ᠳᠤ ᠵᠠᠭᠠᠰᠠᠨ» ᠭᠡᠭᠰᠡᠨ ᠢ «ᠲᠥᠷᠥ ᠶᠢᠨ ᠪᠠ ᠣᠷᠣᠨ ᠨᠤᠲᠤᠭ ᠤᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢᠨ» ᠭᠡᠵᠦ᠂ ᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ «ᠮᠡᠳᠡᠭᠦᠯᠦᠯ᠄» ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ «ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠖.᠑.᠖ – ᠳᠤ ᠵᠠᠭᠠᠰᠠᠨ ᠲᠥᠷᠥ ᠶᠢᠨ ᠪᠠ ᠣᠷᠣᠨ ᠨᠤᠲᠤᠭ ᠤᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢᠨ» ᠭᠡᠭᠰᠡᠨ ᠢ «ᠮᠡᠳᠡᠭᠦᠯᠦᠭᠰᠡᠨ ᠲᠥᠷᠥ ᠶᠢᠨ ᠪᠠ ᠣᠷᠣᠨ ᠨᠤᠲᠤᠭ ᠤᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢᠨ» ᠭᠡᠵᠦ᠂ ᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠖.᠑.᠖ ᠳᠠᠬᠢ «ᠶᠠᠮᠠᠷ» ᠭᠡᠳᠡᠭ ᠢ «ᠲᠥᠷᠥ ᠶᠢᠨ ᠪᠠ» ᠭᠡᠵᠦ᠂ ᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠐᠑ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ «ᠲᠥᠷᠥ ᠶᠢᠨ ᠪᠠ» ᠭᠡᠭᠰᠡᠨ ᠢ «ᠮᠡᠳᠡᠭᠦᠯᠦᠭᠰᠡᠨ» ᠭᠡᠵᠦ᠂ ᠶᠡᠷᠦ ᠶᠢᠨ ᠬᠤᠤᠯᠢ ᠶᠢᠨ «ᠲᠥᠷᠥ ᠶᠢᠨ ᠪᠠ ᠣᠷᠣᠨ ᠨᠤᠲᠤᠭ ᠤᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢᠨ ᠰᠠᠩ ᠤᠨ ᠰᠢᠯᠵᠢᠭᠦᠯᠡᠭ ᠤᠨ ᠲᠥᠰᠦᠪ ᠳᠦ ᠲᠤᠰᠬᠠᠭᠳᠠᠭᠰᠠᠨ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠣᠷᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠵᠠᠷᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢ» ᠭᠡᠭᠰᠡᠨ ᠢ «ᠲᠥᠷᠥ ᠶᠢᠨ ᠪᠠ ᠣᠷᠣᠨ ᠨᠤᠲᠤᠭ ᠤᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢᠨ ᠵᠠᠷᠤᠯᠭ᠎ᠠ᠂ ᠲᠥᠰᠦᠪ᠂ ᠬᠥᠲᠦᠯᠪᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠯᠲᠡ᠄» ᠭᠡᠵᠦ᠂ ᠶᠡᠷᠦ ᠶᠢᠨ ᠬᠤᠤᠯᠢ ᠶᠢᠨ «ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢᠨ ᠵᠠᠷᠤᠯᠭ᠎ᠠ᠂ ᠲᠥᠰᠦᠪ᠂ ᠬᠥᠲᠦᠯᠪᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠯᠲᠡ ᠳᠦ ᠵᠠᠷᠤᠭᠳᠠᠬᠤ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠣᠷᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠳᠦ ᠲᠤᠰᠬᠠᠭᠳᠠᠭᠰᠠᠨ ᠵᠠᠷᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠰᠠᠩ» ᠭᠡᠵᠦ᠂ ᠕.᠑.᠓ ᠳᠠᠬᠢ «ᠡᠨᠡ» ᠭᠡᠭᠰᠡᠨ ᠢ «ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ» ᠭᠡᠵᠦ᠂ ᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠕.᠑ – ᠳᠦ «᠒.᠑» ᠭᠡᠭᠰᠡᠨ ᠢ «᠒» ᠭᠡᠵᠦ᠂ ᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑.᠔ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ «᠑.᠒» ᠭᠡᠭᠰᠡᠨ ᠢ «᠑᠒» ᠭᠡᠵᠦ᠂ ᠖.᠑ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ «᠒» ᠭᠡᠭᠰᠡᠨ ᠢ «᠑᠒» ᠭᠡᠵᠦ᠂ ᠶᠡᠷᠦ ᠶᠢᠨ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ «᠑᠒» ᠭᠡᠭᠰᠡᠨ ᠢ «᠑᠒᠑» ᠭᠡᠵᠦ᠂ ᠖.᠗ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ «᠗.᠑.᠖» ᠭᠡᠭᠰᠡᠨ ᠢ «᠗.᠑᠑.᠖᠑᠑.᠖᠑᠑.᠖᠑᠑» ᠭᠡᠵᠦ᠂ ᠗᠑ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠗.᠑ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ «ᠮᠡᠳᠡᠭᠦᠯᠦᠯ ᠳᠦ» ᠭᠡᠭᠰᠡᠨ ᠢ «ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠵᠠᠷᠯᠢᠭ ᠢᠶᠠᠷ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠳᠠᠭᠰᠠᠨ» ᠭᠡᠵᠦ ᠲᠤᠰ ᠲᠤᠰ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠭᠰᠡᠭᠡᠢ᠃

᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠲᠥᠷᠥ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠓.᠖ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠢ ᠓᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠓.᠓.᠓ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠢ ᠲᠤᠰ ᠲᠤᠰ ᠬᠦᠴᠦᠨ ᠦᠭᠡᠢ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠳᠤ ᠲᠣᠭᠠᠴᠠᠭᠰᠠᠭᠠᠢ᠃

᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠓ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠰᠠᠪᠤᠷ ᠢ ᠬᠠᠰᠤᠭᠰᠠᠨ ᠑ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠒.᠒.᠒᠑᠒ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠢ ᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠑ – ᠨ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠡᠭᠦᠯᠦᠭᠰᠡᠭᠡᠢ᠃

᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠑ – ᠨ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠡᠭᠦᠯᠦᠭᠰᠡᠭᠡᠢ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠳ᠋ᠠ.ᠠᠮᠤᠷᠪᠠᠶᠠᠰᠬᠤᠯᠠᠩ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон 60 насанд хүрсэн эрэгтэй тэтгэвэр авагчид, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэвэр авагчид олгох суурь тэтгэвэр ($С_Т$)-ийн хэмжээг тооцоход баримтлах үзүүлэлтийг Засгийн газраас тогтоохдоо Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзах бөгөөд суурь тэтгэврийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгоно.

**2 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.8 дахь заалтад заасан суурь тэтгэвэрт шаардагдах хөрөнгийг 2027 оны улсын төсөвт тусгана.

**3 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэгт заасан журмыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө батална.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **С.БЯМБАЦОГТ**

ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠕ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠗ — ᠨ ᠤ ᠡᠳᠦᠷ

ᠨᠡᠢᠭᠡᠮ ᠦᠨ ᠳᠠᠭᠠᠲᠭᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ
ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠕ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠗ — ᠨ ᠤ ᠡᠳᠦᠷ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠨᠡᠢᠭᠡᠮ ᠦᠨ ᠳᠠᠭᠠᠲᠭᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ... (Cт) ... ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠭᠰᠡᠭᠡᠢ᠃

᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ... ᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ... ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠡᠨᠡ᠃

᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ... ᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠕ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠗ — ᠨ ᠤ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠡᠨᠡ᠃

᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ... ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ... ᠮᠥᠷᠳᠡᠨᠡ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠳᠠ᠂ᠠᠮᠤᠷᠪᠠᠶᠠᠰᠬᠤᠯᠠᠩ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр | Улаанбаатар хот

## ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:**

“4/суурь тэтгэвэр.”

**2/8 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг:**

“4.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.1-д заасан өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн энэ хуулийн дагуу цэргийн алба хаасны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 2.1.8-д заасан суурь тэтгэвэр олгоно.

5.Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан тэтгэвэр авагчид суурь тэтгэвэр олгох харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн холбогдох заалтаар зохицуулна.”

**3/9 дүгээр зүйлийн 6, 7, 8, 9 дэх хэсэг:**

“6.Доор дурдсан нөхцөл хангасан суурь тэтгэвэр авагчийн нөхөр, эсхүл эхнэр нас барсан тохиолдолд эхнэр, эсхүл нөхрийн авч байгаа суурь тэтгэврийн хэмжээг 50 хувиар нэмэгдүүлэн олгоно:

1/Гэр бүлийн тухай хуулийн 7.1-д зааснаар бүртгүүлсэн;
2/15 ба түүнээс дээш жил хамт амьдарсан;
3/Нөхөр, эхнэр хоёулаа суурь тэтгэвэр авагч байх.

7.Энэ хуулийн 6 дахь хэсэгт заасан суурь тэтгэврийн нэмэгдлийг тэтгэвэр авагчийн нас барсны дараагийн 2 дахь сараас эхлэн олгоно.

8.Энэ хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагч ажил олгогч, хүнтэй хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа тохиолдолд

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасан насанд хүртэл Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.4-т заасан нийгмийн даатгалын төрөлд албан журмаар даатгуулна.

9.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасан тэтгэвэр авагч Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **С.БЯМБАЦОГТ**

ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

ᠪ/ ᠬᠣᠶᠠᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ 6.2 — ᠳᠤ ᠵᠠᠰᠠᠭᠰᠠᠨ ᠬᠦᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ;

ᠸ/ ... ᠬᠤᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠳᠠᠭᠠᠭᠤ ᠳᠤ ᠵᠠᠰᠠᠭᠰᠠᠨ;

ᠭ/ ... ᠪᠤᠶᠤ ᠬᠠᠤᠯᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠮᠵᠢ ᠪᠠᠷ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠭᠰᠠᠨ ᠪᠤᠰᠤᠳ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ::

2. ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤ ᠪᠡᠨ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠭᠰᠠᠨ ᠪᠣᠯᠵᠣᠭᠠᠨ ᠳᠤ ᠬᠠᠮᠢᠷᠤᠭᠳᠠᠬᠤ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠵᠢᠭᠰᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠨ᠎ᠠ ::

3. ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤ ᠨᠢ ᠲᠤᠰ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠯᠲᠡ ᠶᠢ ᠬᠠᠩᠭᠠᠬᠤ ᠲᠠᠢ ᠬᠣᠯᠪᠣᠭᠳᠠᠭᠰᠠᠨ ᠠᠰᠠᠭᠤᠳᠠᠯ ᠢ ᠵᠣᠬᠢᠴᠠᠭᠤᠯᠤᠨ᠎ᠠ᠂ ᠡᠳᠡᠭᠡᠷ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ᠂ ᠦᠦᠷᠭᠡ ᠶᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠬᠤ ᠳᠤ ᠮᠥᠷᠳᠡᠨ᠎ᠡ᠂ ᠬᠤᠤᠯᠢ ᠶᠢᠨ 4.1.3 — ᠳᠤ ᠵᠠᠰᠠᠭᠰᠠᠨ ᠡᠷᠬᠡ ᠶᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠳᠦᠷᠢᠮ ᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠨ᠎ᠠ᠂ 4.1.3.1᠂ 4.1.3.3᠂ 4.1.3.4 — ᠳᠤ ᠵᠠᠰᠠᠭᠰᠠᠨ ᠡᠷᠬᠡ ᠶᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠨ᠎ᠠ ::

4. ᠡᠷᠬᠡ ᠶᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠬᠤ ᠳᠠᠭᠠᠨ ᠬᠤᠤᠯᠢ ᠶᠢᠨ 4.1.3 — ᠳᠤ ᠵᠠᠰᠠᠭᠰᠠᠨ ᠪᠣᠯᠵᠣᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠᠯᠠᠨ᠎ᠠ᠂ ᠬᠤᠤᠯᠢ ᠶᠢᠨ 4.1.3 — ᠳᠤ ᠵᠠᠰᠠᠭᠰᠠᠨ ᠡᠷᠬᠡ ᠶᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠪᠡᠷ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠭᠳᠠᠨ᠎ᠠ »::

4 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ. ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ 2026 ᠣᠨ ᠤ 6 ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ 1 — ᠨ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠡᠬᠦ ᠪᠥᠭᠡᠳ᠂ ᠲᠤᠰ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠯᠲᠡ ᠶᠢ ᠬᠠᠩᠭᠠᠬᠤ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠨ᠎ᠠ ::

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠳ᠋ᠠ᠂ ᠠᠮᠤᠷᠪᠠᠶᠠᠰᠬᠤᠯᠠᠩ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

## ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон 60 насанд хүрсэн эрэгтэй тэтгэвэр авагчид, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэвэр авагчид суурь тэтгэвэр ($C_T$)-ийг тооцон олгоно.

**2 дугаар зүйл.**Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш шинээр тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн өдрөөс суурь тэтгэвэр ($C_T$)-ийг тооцон олгоно.

**3 дугаар зүйл.**Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан суурь тэтгэвэрт шаардагдах хөрөнгийг 2027 оны улсын төсөвт тусгана.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд  доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/2 дугаар зүйлийн 2.1.5, 2.1.6 дахь заалт:**

“2.1.5.ажилгүйдлийн тэтгэмж;
2.1.6.шимтгэлийн хөнгөлөлт.”

**2/4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг:**

“4.3.Энэ хуулийн 4.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхойлно.”

**3/7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх хэсэг:**

“7.3.Жирэмсний тэтгэмжийг төрөхийн өмнөх 60 хоногийн, амаржсаны тэтгэмжийг төрсний дараах 60 хоногийн, ихэр хүүхэд төрүүлсэн бол 80 хоногийн доторх ажлын өдрөөр тус тус тооцож олгоно.

7.4.Энэ хуулийн 7.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхойлно.”

**4/10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг:**

“10.3.Энэ хуулийн 10.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж ажилгүйдлийн тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхойлно.”

**2 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “авч байсан” гэсний дараа “энэ хуулийн 8.1-д заасан нөхцөлийг хангасан” гэж, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “жагсаалт, тэтгэмж” гэсний дараа “тооцож” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“11.1.Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг ажлаас чөлөөлөгдсөний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрөөр, харин өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн бол ажлын 55 өдрөөр тооцож олгоно.”

**4 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “шимтгэлийн төлбөрийг олгоно:” гэснийг “шимтгэлийн төлбөр, хөнгөлөлтийг олгоно:” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “9” гэснийг “12” гэж, 9.2 дахь хэсгийн “3” гэснийг “9” гэж, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсгийн “9” гэснийг “12” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж гаргуулаагүй” гэснийг “тэтгэмжийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж гаргуулаагүй” гэж, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “ажилгүйдлийн” гэснийг “тэтгэмжийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийн 3, 4 дүгээр зүйлийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠭᠤᠯᠢ

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠗ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠒ – ᠨ ᠡᠳᠦᠷ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

[illegible] ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠳᠤ
ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ᠂ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ [illegible] ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠳᠤ ᠳᠣᠣᠷ᠎ᠠ ᠳᠤᠷᠠᠳᠬᠠᠰᠠᠨ ᠠᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠲᠠᠢ ᠳᠠᠷᠠᠭᠠᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ᠂ ᠬᠡᠰᠡᠭ ᠨᠡᠮᠡᠰᠦᠭᠡᠢ:

᠑/᠒ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠒.᠑.᠔᠂ ᠒.᠑.᠖ ᠳᠡᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠤᠳ:

«᠒.᠑.᠔.[illegible];

᠒.᠑.᠖.[illegible]᠃»

᠒/᠕ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠕.᠒ ᠳᠡᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ:

«᠕.᠒.[illegible]᠃»

᠒/᠗ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠗.᠒᠂ ᠗.᠕ ᠳᠡᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ:

«᠗.᠒.[illegible] ᠑᠐ ᠨᠠᠰᠤ ᠪᠠᠷ᠂ [illegible] ᠔᠐ ᠨᠠᠰᠤ ᠪᠠᠷ [illegible]᠃

᠗.᠕.[illegible]᠃»

᠕/᠑᠐ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑᠐.᠒ ᠳᠡᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ:

«᠑᠐.᠒.[illegible]᠃»

«᠓᠐·᠔·᠑· ᠨᠡᠷᠡᠳᠦᠯ ᠦᠨ ᠪᠠᠭᠠᠨ᠎ᠠ ᠳᠤ ᠓᠐·᠑ ― ᠳᠦ ᠵᠠᠰᠠᠭᠯᠠᠭᠰᠠᠨ ᠪᠠ ᠪᠣᠯᠣᠰᠤᠷᠠᠩᠭᠤᠢ ᠪᠣᠯᠭᠠᠭᠰᠠᠨ ᠡᠳ ᠦᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ᠂ ᠪᠠᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠡᠮᠦᠨ᠎ᠡ ᠬᠦᠯᠢᠶᠡᠬᠦ ᠡᠳ ᠦᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠬᠤ ᠠᠵᠢᠯ ᠠᠯᠪᠠ ᠳᠤ ᠴᠢᠭᠯᠡᠭᠦᠯᠬᠦ ᠳᠦ ᠓᠑ ― ᠳᠦ ᠲᠤᠰᠬᠠᠭᠳᠠᠭᠰᠠᠨ ᠪᠠᠢᠨ᠎ᠠ᠃»

᠒ ᠬᠦᠰᠦᠨᠦᠭᠲᠦ ᠶᠢᠨ ᠄ ᠨᠡᠷᠡᠳᠦᠯ ᠦᠨ ᠪᠠᠭᠠᠨ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠵᠢᠷᠤᠭᠠᠳᠤᠭᠠᠷ ᠮᠦᠷ ᠦᠨ ᠓·᠒ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ ᠒·᠒ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ «ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ» ᠭᠡᠰᠡᠨ ᠢ «ᠨᠡᠷᠡᠳᠦᠯ ᠦᠨ ᠪᠠᠭᠠᠨ᠎ᠠ ᠳᠤ ᠓·᠒ ― ᠳᠦ ᠵᠠᠰᠠᠭᠯᠠᠭᠰᠠᠨ ᠡᠷᠦᠬᠡ ᠶᠢᠨ ᠠᠵᠢᠯᠲᠠᠨ» ᠭᠡᠵᠦ᠂ ᠒᠔ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ ᠒᠔·᠒ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ «ᠠᠵᠢᠯᠯᠠᠭᠠᠳ᠂ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ» ᠭᠡᠰᠡᠨ ᠢ «ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ» ᠭᠡᠵᠦ ᠲᠤᠰ ᠲᠤᠰ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠭᠰᠦᠭᠡᠢ᠃

᠓ ᠬᠦᠰᠦᠨᠦᠭᠲᠦ ᠶᠢᠨ ᠄ ᠨᠡᠷᠡᠳᠦᠯ ᠦᠨ ᠪᠠᠭᠠᠨ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠵᠢᠷᠤᠭᠠᠳᠤᠭᠠᠷ ᠮᠦᠷ ᠦᠨ ᠑᠑ ᠳᠤᠭᠠᠷ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ ᠑᠑·᠑ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢ ᠳᠠᠷᠠᠭᠠᠬᠢ ᠠᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠲᠠᠢ ᠪᠠᠷ ᠨᠡᠮᠡᠭᠰᠦᠭᠡᠢ᠄

«᠑᠑·᠑·ᠠᠵᠢᠯᠯᠠᠭᠠᠨ ᠤ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠳᠦ ᠡᠷᠦᠬᠡ ᠶᠢᠨ ᠡᠳ ᠦᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠢᠵᠦ ᠪᠠᠢᠬᠤ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠡᠨ ᠳᠦ ᠠᠵᠢᠯᠯᠠᠬᠤ ᠡᠷᠦᠬᠡ ᠶᠢᠨ ᠬᠦᠮᠦᠨ ᠦ ᠡᠷᠦᠬᠡ ᠶᠢᠨ ᠒᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠳᠦ ᠵᠠᠰᠠᠭᠯᠠᠭᠰᠠᠨ ᠪᠣᠯᠬᠤ᠃»

᠔ ᠬᠦᠰᠦᠨᠦᠭᠲᠦ ᠶᠢᠨ ᠄ ᠨᠡᠷᠡᠳᠦᠯ ᠦᠨ ᠪᠠᠭᠠᠨ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠵᠢᠷᠤᠭᠠᠳᠤᠭᠠᠷ ᠮᠦᠷ ᠦᠨ ᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ ᠔·᠑ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ «ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠶᠢᠨ ᠲᠥᠯᠦᠭᠡ ᠬᠢᠵᠦ᠄» ᠭᠡᠰᠡᠨ ᠢ «ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠶᠢᠨ ᠲᠥᠯᠦᠭᠡ᠂ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠢᠵᠦ᠄» ᠭᠡᠵᠦ᠂ ᠕ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ ᠕·᠑ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ «᠕» ᠭᠡᠰᠡᠨ ᠢ «᠖» ᠭᠡᠵᠦ᠂ ᠕·᠑·᠑᠐᠂ ᠕·᠑·᠑᠑ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ «᠕» ᠭᠡᠰᠡᠨ ᠢ «᠖» ᠭᠡᠵᠦ᠂ ᠑᠓ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ ᠑᠓·᠑ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ «ᠡᠷᠦᠬᠡ ᠶᠢᠨ ᠠᠵᠢᠯᠲᠠᠨ ᠤ ᠡᠳ ᠦᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠬᠦᠯᠢᠶᠡᠨ ᠵᠦᠪᠰᠢᠶᠡᠷᠡᠬᠦ ᠪᠠᠷ» ᠭᠡᠰᠡᠨ ᠢ «ᠡᠳ ᠦᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠬᠦᠯᠢᠶᠡᠨ ᠵᠦᠪᠰᠢᠶᠡᠷᠡᠬᠦ ᠪᠠᠷ» ᠭᠡᠵᠦ᠂ ᠑᠖ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ ᠑᠖·᠑ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ «ᠡᠷᠦᠬᠡ ᠶᠢᠨ ᠠᠵᠢᠯᠲᠠᠨ ᠤ» ᠭᠡᠰᠡᠨ ᠢ «ᠡᠳ ᠦᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ» ᠭᠡᠵᠦ ᠲᠤᠰ ᠲᠤᠰ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠭᠰᠦᠭᠡᠢ᠃

᠕ ᠬᠦᠰᠦᠨᠦᠭᠲᠦ ᠶᠢᠨ ᠄ ᠨᠡᠷᠡᠳᠦᠯ ᠦᠨ ᠪᠠᠭᠠᠨ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠵᠢᠷᠤᠭᠠᠳᠤᠭᠠᠷ ᠮᠦᠷ ᠦᠨ ᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ ᠔·᠓ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢ ᠬᠦᠴᠦᠨ ᠦᠭᠡᠢ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠳᠤ ᠲᠤᠭᠠᠴᠠᠭᠰᠤᠭᠠᠢ᠃

᠖ ᠬᠦᠰᠦᠨᠦᠭᠲᠦ ᠶᠢᠨ ᠄ ᠨᠡᠷᠡᠳᠦᠯ ᠦᠨ ᠪᠠᠭᠠᠨ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠓·᠗ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ ᠑᠙᠘᠐ ᠣᠨ ᠤ ᠑᠐ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ ᠑᠐ ― ᠤ ᠵᠦᠢᠯ ᠢ ᠬᠠᠰᠤᠭᠰᠤᠭᠠᠢ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ

ᠳ·ᠠᠮᠠᠷᠪᠠᠶᠠᠰᠬᠤᠯᠠᠩ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

**1/4$^{1}$ дүгээр зүйл:**

“**4$^{1}$ дүгээр зүйл.Суурь тэтгэвэр олгох**

4$^{1}$.1.Энэ хуулийн дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгосон бөгөөд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн тэтгэвэр авагчид мөн хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.8-д заасан суурь тэтгэвэр олгоно.

4$^{1}$.2.Энэ хуулийн 4$^{1}$.1 дэх хэсэгт заасан тэтгэвэр авагчид суурь тэтгэвэр олгох харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн холбогдох заалтаар зохицуулна.”

**2/9 дүгээр зүйлийн 9.3.4 дэх заалт:**

“9.3.4.энэ хуулийн 9.3.1, 9.3.2, 9.3.3-т зааснчы дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг.”

**3/14 дүгээр зүйлийн 14.1.4-14.1.7 дахь заалт:**

“14.1.4.мэргэжлээс шалтгаалсан өвчний онош баталгаажуулах, хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоохтой холбоотой эмнэлгийн үзлэг, шинжилгээний;

14.1.5.хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан, онош баталгаажуулахтай холбоотой хөдөлмөрийн нөхцөлийг судлан тогтоох хэмжилт, лабораторийн шинжилгээний;

14.1.6.хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчид үзүүлэх хөдөлмөрийн сэргээн засах, гэрээр асрах, сувилах болон хувилбарт тусламж үйлчилгээний;

14.1.7.даатгуулагчийн хөдөлмөрийн чадварыг хадгалах, сэргээн засах төлөвлөгөө боловсруулах, эмчилгээ, сувилгааны хэрэгцээг тодорхойлох, үр дүнг хянахад чиглэсэн эмнэлгийн хяналтын үзлэг, шинжилгээний.”

**2 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.1 дэх заалтын “өмнөх” гэсний дараа “сүүлийн” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/2 дугаар зүйлийн 2.1.2 дахь заалт:**

“2.1.2.“эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.1.10.в-д заасныг;”

**2/3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг:**

“3.4.Мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалтыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”

**3/4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалт:**

“4.1.7.даатгуулагчийн эрүүл мэнд, хөдөлмөрийн сэргээн засах зардлын төлбөр;”

**4/13 дугаар зүйлийн 13.1.3, 13.1.4 дэх заалт:**

“13.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлсэн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сайн туршлагыг сурталчлах;

13.1.4.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан, нөхцөлийг судлах, хөдөлмөрийн аюулгүй байдал,

эрүүл мэндийн техникийн зохицуулалтыг боловсруулах, урьдчилан сэргийлэлтийн талаарх бодлого, шийдвэр, хэрэгжилтийг үнэлэхэд чиглэсэн судалгаа, эрдэм шинжилгээ, хяналт, шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ.”

**4 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд дараах сургалт, сурталчилгаа, судалгааны ажлыг” гэснийг “өвчний урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дараах арга хэмжээг” гэж, мөн зүйлийн 13.2 дахь хэсгийн “2 хувиас багагүй” гэснийг “3 хувиас хэтрэхгүй” гэж, Дөрөвдүгээр бүлгийн гарчгийн “**ЭРҮҮЛ МЭНДИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ**” гэснийг “**ДААТГУУЛАГЧИЙН ЭРҮҮЛ МЭНД, ХӨДӨЛМӨРИЙН СЭРГЭЭН ЗАСАЛТ**” гэж, 14 дүгээр зүйлийн гарчгийн “**Эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр**” гэснийг “**Эрүүл мэнд, хөдөлмөрийн сэргээн засах зардлын төлбөр**” гэж, мөн зүйлийн 14.1.1 дэх заалтын, 14.2, 14.3, 14.4, 14.5 дахь хэсгийн “протез, ортопедийн” гэснийг “эмнэлгийн хэрэглэгдэхүүний” гэж, мөн зүйлийн 14.4 дэх хэсгийн “протез, ортопедийг” гэснийг “эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **С.БЯМБАЦОГТ**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ [illegible] ᠡᠳᠦᠷ — ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

[illegible] ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ᠂ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠣᠷᠤᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ. [illegible]

᠑/᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ:

«᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ. [illegible]

᠑.᠑. [illegible]

᠑.᠒. [illegible]»

᠒/᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠒.᠓.᠑ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲ:

«᠒.᠓.᠑. [illegible]»

᠔/᠑᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑᠑.᠑.᠑ – ᠑᠑.᠑.᠓ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲ:

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

«᠕.᠑.᠗.ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠦᠮᠦᠨ ᠠᠮᠢ᠂ ᠪᠠᠶᠢᠭᠠᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠣᠷᠢᠭᠯᠠᠯ ᠲᠤᠰᠬᠠᠢ ᠨᠦᠬᠦᠴᠡᠯ ᠦᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ;»

᠕/᠑᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑᠒.᠑.᠒᠂ ᠑᠒.᠑.᠕ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠰᠠᠯᠲᠠ:

«᠑᠒.᠑.᠒.ᠪᠠᠶᠢᠭᠠᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠦᠮᠦᠨ ᠠᠮᠢ ᠶᠢᠨ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠳᠦᠷᠢᠮ ᠵᠢᠷᠤᠮ ᠢ ᠪᠠᠳᠤᠯᠠᠬᠤ ᠪᠣᠯᠤᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠬᠤ᠂ ᠬᠤᠪᠢ ᠬᠦᠮᠦᠨ᠂ ᠠᠵᠢ ᠠᠬᠤᠢ ᠶᠢᠨ ᠨᠡᠭᠡᠴᠡ᠂ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠰᠤᠷᠭᠠᠯᠲᠠ᠂ ᠵᠥᠪᠯᠡᠭᠡ ᠥᠭᠬᠦ᠂ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠬᠢᠬᠦ;»

«᠑᠒.᠑.᠕.ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠦᠮᠦᠨ ᠠᠮᠢ᠂ ᠪᠠᠶᠢᠭᠠᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠣᠷᠢᠭᠯᠠᠯ ᠲᠤᠰᠬᠠᠢ ᠳᠦᠷᠢᠮ ᠵᠢᠷᠤᠮ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠳᠤ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠬᠢᠬᠦ᠂ ᠲᠠᠢᠯᠠᠩ ᠲᠠᠨᠢᠯᠴᠠᠭᠤᠯᠬᠤ᠂ ᠵᠥᠪᠯᠡᠭᠡ ᠥᠭᠬᠦ᠂ ᠰᠤᠷᠭᠠᠯᠲᠠ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ;»

᠕ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠄ ᠬᠣᠷᠢᠭᠯᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠑᠒.᠑ ᠳᠠᠬᠢ «ᠬᠣᠷᠢᠭᠯᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ» ᠭᠡᠰᠡᠨ ᠢ «ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠣᠷᠢᠭᠯᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠪᠣᠳᠤᠯᠭ᠎ᠠ᠂ ᠲᠥᠯᠥᠪᠯᠡᠭᠡ᠂ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠳᠦᠷᠢᠮ ᠵᠢᠷᠤᠮ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ᠂ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ᠂ ᠬᠢᠨᠠᠬᠤ᠂ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ᠂ ᠳᠡᠮᠵᠢᠬᠦ ᠶᠢ ᠬᠠᠩᠭᠠᠬᠤ᠃»

᠔ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠄ ᠬᠣᠷᠢᠭᠯᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠑᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑᠒.᠑ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ «ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ᠂ ᠠᠵᠢ ᠠᠬᠤᠢ ᠶᠢᠨ ᠨᠡᠭᠡᠴᠡ» ᠭᠡᠰᠡᠨ ᠢ «ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠦᠮᠦᠨ ᠠᠮᠢ᠂ ᠪᠠᠶᠢᠭᠠᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠣᠷᠢᠭᠯᠠᠯ ᠲᠤᠰᠬᠠᠢ» ᠭᠡᠵᠦ᠂ ᠑᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ «ᠪᠠᠶᠢᠭᠠᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠦᠮᠦᠨ ᠠᠮᠢ ᠶᠢᠨ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠪᠣᠳᠤᠯᠭ᠎ᠠ» ᠭᠡᠰᠡᠨ ᠢ «ᠪᠠᠶᠢᠭᠠᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠦᠮᠦᠨ ᠠᠮᠢ᠂ ᠪᠠᠶᠢᠭᠠᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠣᠷᠢᠭᠯᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ» ᠭᠡᠵᠦ᠂ ᠑᠒.᠑.᠑᠂ ᠑᠒.᠑.᠒᠂ ᠑᠒.᠑.᠔᠂ ᠑᠒.᠑.᠕ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠰᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ «ᠬᠣᠷᠢᠭᠯᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ» ᠭᠡᠰᠡᠨ ᠢ «ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ᠂ ᠠᠵᠢ ᠠᠬᠤᠢ ᠶᠢᠨ ᠨᠡᠭᠡᠴᠡ ᠶᠢᠨ» ᠭᠡᠵᠦ ᠲᠤᠰ ᠲᠤᠰ ᠥᠭᠡ ᠨᠡᠮᠡᠵᠦ ᠥᠭᠡᠴᠢᠯᠡᠭᠰᠡᠭᠦᠢ᠃

᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠄ ᠬᠣᠷᠢᠭᠯᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠗.᠑.᠓ ᠳᠠᠬᠢ «ᠬᠣᠷᠢᠭᠯᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ» ᠭᠡᠰᠡᠨ ᠢ «ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠦᠮᠦᠨ ᠠᠮᠢ᠂ ᠪᠠᠶᠢᠭᠠᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠣᠷᠢᠭᠯᠠᠯ ᠤᠨ» ᠭᠡᠵᠦ ᠥᠭᠡ ᠨᠡᠮᠡᠵᠦ ᠥᠭᠡᠴᠢᠯᠡᠭᠰᠡᠭᠦᠢ᠃

᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠄ ᠬᠣᠷᠢᠭᠯᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠔.᠑.᠔ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠰᠠᠯᠲᠠ ᠶᠢ ᠳᠣᠣᠷ᠎ᠠ ᠳᠤᠷᠠᠳᠬᠠᠯ ᠶᠢ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ᠂ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ᠂ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠲᠠᠢ ᠬᠣᠯᠪᠣᠭᠳᠠᠬᠤ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠵᠣᠬᠢᠴᠠᠭᠤᠯᠬᠤ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ

ᠳ.ᠠᠮᠠᠷᠪᠠᠶᠠᠰᠭᠠᠯᠠᠨ

᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠄ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠑-ᠨ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠡᠨ᠎ᠡ᠃

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон 60 насанд хүрсэн эрэгтэй тэтгэвэр авагчид, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэвэр авагчид олгох суурь тэтгэвэр ($С_Т$)-ийн хэмжээг тооцоход баримтлах үзүүлэлтийг Засгийн газраас тогтоохдоо Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзах бөгөөд суурь тэтгэврийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгоно.

**2 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш шинээр тэтгэвэр тогтоолгосон эрэгтэй тэтгэвэр авагчид 60 насанд, эмэгтэй тэтгэвэр авагчид 55 насанд хүрсэн өдрөөс суурь тэтгэвэр ($С_Т$)-ийг тооцон олгоно.

**3 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн $4^1$ дүгээр зүйлийн $4^1$.1 дэх хэсэгт заасан суурь тэтгэвэрт шаардагдах хөрөнгийг 2027 оны улсын төсөвт тусгана.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ**

[illegible]

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 03-ны өдөр — Улаанбаатар хот

## ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Газрын тосны тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн “хуваалтыг тухайн гэрээнд заасан хувь, хэмжээгээр зохицуулах ба энэ хуулийн 17.3.2-т заасан нөөц ашигласны төлбөр төлөхгүй байгаа гэрээний тухайд төрийн захиргааны байгууллага гэрээлэгчтэй харилцан тохиролцож уг төлбөрийн хэмжээг тогтооно.” гэснийг “хуваалт болон татвар, шимтгэлийг тухайн гэрээнд заасан хувь, хэмжээгээр зохицуулна.” гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** — **С.БЯМБАЦОГТ**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠓ ᠤ ᠡᠳᠦᠷ — ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠲᠣᠰᠣᠨ ᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ
ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠲᠣᠰᠣᠨ ᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠔᠕ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠔᠕.᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ «ᠬᠤᠪᠢᠶᠠᠷᠢ ᠶᠢ ᠲᠤᠬᠠᠢ ᠶᠢᠨ ᠭᠡᠷ᠎ᠡ ᠳᠦ ᠵᠠᠭᠠᠰᠠᠨ ᠬᠤᠪᠢ᠂ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠪᠡᠷ ᠵᠣᠬᠢᠴᠠᠭᠤᠯᠬᠤ ᠪᠠ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠑᠗.᠓.᠒ ᠳᠤ ᠵᠠᠭᠠᠰᠠᠨ ᠨᠥᠭᠡᠴᠡ ᠠᠰᠢᠭᠯᠠᠭᠰᠠᠨ ᠤ ᠲᠥᠯᠥᠪᠦᠷᠢ ᠲᠥᠯᠥᠬᠦ ᠦᠭᠡᠢ ᠪᠠᠶᠢᠭ᠎ᠠ ᠭᠡᠷ᠎ᠡ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠳᠤ ᠲᠣᠷᠣ ᠶᠢᠨ ᠵᠠᠬᠢᠷᠭᠠᠨ ᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠭᠡᠷ᠎ᠡ ᠯᠡᠭᠴᠢ ᠲᠡᠢ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠨ ᠲᠣᠬᠢᠷᠠᠯᠴᠠᠵᠤ ᠤᠭ ᠲᠥᠯᠥᠪᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠨ᠎ᠠ᠃» ᠭᠡᠭᠰᠡᠨ ᠢ «ᠬᠤᠪᠢᠶᠠᠷᠢ ᠪᠣᠯᠣᠨ ᠲᠠᠲᠠᠪᠤᠷᠢ᠂ ᠰᠢᠮᠲᠡᠭᠡᠯ ᠢ ᠲᠤᠬᠠᠢ ᠶᠢᠨ ᠭᠡᠷ᠎ᠡ ᠳᠦ ᠵᠠᠭᠠᠰᠠᠨ ᠬᠤᠪᠢ᠂ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠪᠡᠷ ᠵᠣᠬᠢᠴᠠᠭᠤᠯᠤᠨ᠎ᠠ᠃» ᠭᠡᠵᠦ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠰᠦᠭᠡᠢ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ — ᠰ᠊ ᠪᠢᠮᠪᠠᠴᠣᠭ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

## ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр баталсан Газрын тосны тухай хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбогдож үүссэн татвар, шимтгэл, актын төлбөрийг тухайн жилийн төсвийн тухай хуульд тусган бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан Монгол Улсын Засгийн газарт ногдох газрын тосны төлбөрт суутган тооцно.

**2 дугаар зүйл.**Тосон-Уул XIX талбайн нөөц ашигласны төлбөртэй холбоотой үүссэн асуудлыг бүтээгдэхүүн хуваах гэрээний 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу ашигт газрын тосны Монгол Улсын Засгийн газарт ногдох хэсэгт багтаан тооцно.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийн 2 дугаар зүйлд заасан нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг цаашид бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу ашигт газрын тосны Монгол Улсын Засгийн газарт ногдох хэсэгт багтаан нийт газрын тосны 7.5 хувиар тооцно.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 03-ны өдөр баталсан Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **С.БЯМБАЦОГТ**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠓ — ᠤ ᠡᠳᠦᠷ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

# ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠦᠨᠳᠦᠰᠦᠲᠡᠨ ᠦ ᠪᠢᠴᠢᠭ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ :: ᠑᠙᠙᠙ ᠣᠨ ᠤ ᠐᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠒᠘ — ᠤ ᠡᠳᠦᠷ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠦᠨᠳᠦᠰᠦᠲᠡᠨ ᠦ ᠪᠢᠴᠢᠭ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠳᠠᠷᠠᠭᠠᠬᠢ ᠠᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠲᠠᠢ ᠵᠦᠢᠯ ᠨᠡᠮᠡᠭᠰᠡᠭᠡᠢ :: ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠦᠨᠳᠦᠰᠦᠲᠡᠨ ᠦ ᠪᠢᠴᠢᠭ ᠪᠣᠯ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠦᠨᠳᠦᠰᠦᠲᠡᠨ ᠦ ᠪᠢᠴᠢᠭ ᠦᠨ ᠥᠪ ᠰᠣᠶᠣᠯ ᠤᠨ ᠥᠪ ᠮᠥᠨ ::

᠒ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ :: ᠮᠣᠩᠭᠣᠯ—ᠮᠠᠨᠵᠤ XIX ᠵᠠᠭᠤᠨ ᠤ ᠦᠶ᠎ᠡ ᠶᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠦᠨᠳᠦᠰᠦᠲᠡᠨ ᠦ ᠪᠢᠴᠢᠭ ᠦᠨ ᠥᠪ ᠢ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠕᠐᠔ — ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠦᠨᠳᠦᠰᠦᠲᠡᠨ ᠦ ᠪᠢᠴᠢᠭ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠭᠰᠡᠭᠡᠢ ::

᠓ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ :: ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠓ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠦᠨᠳᠦᠰᠦᠲᠡᠨ ᠦ ᠪᠢᠴᠢᠭ ᠦᠨ ᠥᠪ ᠢ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠘.᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠳᠦ ᠨᠡᠮᠡᠭᠰᠡᠭᠡᠢ ::

᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ :: ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠢ ᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠓ — ᠤ ᠡᠳᠦᠷ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠭᠦᠯᠳᠦᠷ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠡᠨ᠎ᠡ ::

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ

ᠳ᠂ ᠠᠮᠠᠷᠪᠠᠶᠠᠰᠭᠤᠯᠠᠩ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 03-ны өдөр — Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 46 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 46.4 дэх хэсэг нэмсүгэй:

“46.4.1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр баталсан Газрын тосны тухай хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх харилцааг тухайн бүтээгдэхүүн хуваах гэрээгээр зохицуулна.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 03-ны өдөр баталсан Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — С.БЯМБАЦОГТ**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр баталсан Газрын тосны тухай хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбогдож үүссэн нийгмийн даатгалын шимтгэл, актын төлбөрийг тухайн бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан Монгол Улсын Засгийн газарт ногдох газрын тосны төлбөрт тухай бүр суутган тооцно.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 03-ны өдөр баталсан Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **С.БЯМБАЦОГТ**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 03-ны өдөр — Улаанбаатар хот

## ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 4.1.3 дахь заалт нэмсүгэй:

“4.1.3.1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр баталсан Газрын тосны тухай хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээг олон улсын гэрээтэй адилтган холбогдох татварыг тухайн бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу зохицуулах.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 03-ны өдөр баталсан Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — С.БЯМБАЦОГТ**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 07 дугаар сарын 03-ны өдөр — Улаанбаатар хот

## ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр баталсан Газрын тосны тухай хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбогдож үүссэн татвар, актын төлбөрийг тухайн жилийн төсвийн тухай хуульд тусган бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан Монгол Улсын Засгийн газарт ногдох газрын тосны төлбөрт суутган тооцно.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 03-ны өдөр баталсан Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** — **С.БЯМБАЦОГТ**

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 25 | Улаанбаатар хот

**Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг Монгол Улсын Их Хурал хэлэлцсэнтэй холбогдуулан хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, дэмжих чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай:

**1/Хүүхэд хамгааллын тогтолцооны талаар анхаарах зарим асуудлаар:**

а/үе тэнгийн болон цахим орчны дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүний хор нөлөөг арилгах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал боловсруулах, хүний нөөц, ур чадвар, холбогдох салбар дундын зохион байгуулалт, уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах;

б/хүүхдийг мансуурах болон сэтгэцэд нөлөөт бодист автахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны үр дүнг үнэлж, танилцуулах;

в/хүүхэд хамгааллын үндэсний тогтолцооны бүрэлдэхүүн хэсэгт хамаарах бүтэц, нэгж тус бүрийн хуулиар хүлээсэн чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлын хэмжээг тэдний бодит хэрэгцээ, үйлчилгээний хүртээмжтэй уялдуулан тогтоож, санхүүжилтийг шийдвэрлэх асуудлаар санал боловсруулах;

г/шинээр томилогдсон болон ажиллаж байгаа албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, чиг үүргийн онцлогт нийцсэн чадавхжуулах болон давтан сургалтыг тогтмол зохион байгуулах;

д/хүүхэд хамгааллын чиглэлээр иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах хүрээг нэмэгдүүлэх, төрийн чиг үүргийг тэдгээр байгууллагаар гүйцэтгүүлж байгаа тохиолдолд хүүхэд хамгааллын үйлчилгээний хувьсах зардлыг олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжид хэрхэн тусгах санал боловсруулах;

е/хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн орчин, нөхцөлийг хүүхдийн ялгаатай хэрэгцээ болон тэдний онцлог байдалд нийцүүлэн сайжруулах;

ё/нэг цэгийн үйлчилгээний төвийн стандарт болон Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан холбогдох дүрэм, журам, бусад эрх зүйн баримт бичгийг батлах;

ж/хүүхэд хамгааллын үндэсний тогтолцооны бүрэлдэхүүн хэсэгт хамаарах бүтэц, нэгж тус бүрийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тэдний хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, дотоод хяналтын механизмыг боловсронгуй болгох, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хариу арга хэмжээг шуурхай авах тогтолцоог бүрдүүлэх;

з/хүүхдийн төлөө сангийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа төсөл, арга хэмжээний ач холбогдол, үр нөлөөний байдалд дүн шинжилгээ хийж, уг дүн шинжилгээний үр дүнд үндэслэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу төсөл, арга хэмжээ, санхүүжилтийн хэмжээг тогтоох, зарцуулалтын нээлттэй, ил тод байдлыг хангах зохицуулалтын хэрэгжилтийг сайжруулах;

и/Хүүхэд хамгааллын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт заасан “Хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн сан”-г бүрдүүлж, ашиглалтад оруулах;

к/Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах гэрээнд хүүхдийн оролцоонд үндэслэн хүүхэд хамгааллын төлөвлөгөө боловсруулж, батлан хэрэгжүүлэх, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангах механизмыг бүрдүүлэх зохицуулалтыг тусгах;

л/аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд хүүхдэд ээлтэй, аюулгүй орчны үнэлгээг тогтмол хийж, уг үнэлгээг хийхдээ хүүхдийн оролцоог хангах, үнэлгээний үр дүнд үндэслэн эрсдэлийн түвшингээр эрэмбэлсэн хүүхдэд ээлтэй, аюулгүй орчныг бүрдүүлэх

чиглэлээр аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах, хэрэгжүүлэх арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулан зохих журмын дагуу батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

м/аймаг, нийслэлийн хэмжээнд эрсдэлт нөхцөлд байгаа болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хичээлээс гадуурх сургалт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх арга хэмжээ, нийгмийн оролцооны хөтөлбөрт тогтмол хамруулах бодлого хэрэгжүүлэх;

н/хүүхэд хамгааллын салбарт ажиллаж байгаа ажилтнуудын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, ажлаас халшрах хам шинжээс урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх.

**2/Иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхийн хэрэгжилтийн талаар:**

а/эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд үндэслэн эрүүл мэндийн салбарын стандарт, захиргааны хэм хэмжээний актыг шинэчлэх, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтны эрх зүйн байдлыг тодорхойлох болон шинээр нэвтрүүлж байгаа сувилахуйн болон асрахуйн мэргэшсэн тусламж, үйлчилгээтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах;

б/хүний эрүүл мэндэд үзүүлэх үр нөлөө нь шинжлэх ухаанаар нотлогдоогүй мэдээллийг олон нийтийн сүлжээгээр цацаж түгээхийг хориглосон хуулийн зохицуулалтын хэрэгжилтийг сайжруулах, мэргэжлийн бус хүмүүсийн олон нийтийн эрүүл мэндэд хор хохирол учруулахуйц асуудлаар төөрөгдүүлсэн мэдээлэл, зар сурталчилгааг нийтэд түгээхийг хориглох, энэ зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хэрэгжилтэд хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгах санал боловсруулах;

в/эрүүл мэндийн тогтолцоо, шинжлэх ухааны нотолгоо, эрүүл мэндийн технологийн үнэлгээнд тулгуурлан үндэсний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцыг шинээр тодорхойлох;

г/нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг салбарын тэргүүлэх чиглэл болгож, санхүүжилтийг үе шаттайгаар нэмэгдүүлэх санал боловсруулах, салбар дундын бодлогыг уялдуулах;

д/төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад зайлшгүй шаардлагатай эмийн нөөцийн хангалтыг нэмэгдүүлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хяналт, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх;

е/эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг алслагдсан бүс нутагт мэдээллийн технологи, харилцаа холбооны хэрэгслийг ашиглан зайнаас үзүүлэх болон хөдөлгөөнт үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, “хүн төвтэй” нэгдмэл тусламж, үйлчилгээг хөгжүүлэх, яаралтай түргэн тусламжийн дуудлагын бүртгэл, мэдээллийг сайжруулж, хуурамч дуудлагаас үүдэлтэй хохирлыг нөхөн төлүүлэх механизмыг нэвтрүүлэх;

ё/үйлчлүүлэгчийн хувийн мэдээллийг хамгаалах, нэр төр, алдар хүнд халдашгүй байх эрхийг хангах, мэдээлэл авах болон шийдвэр гаргахад оролцох эрхийг баталгаажуулах, халдварт өвчний шалтгаант ялгаварлан гадуурхалтыг бууруулах, гомдлыг үр дүнтэй шийдвэрлэх механизмыг бэхжүүлэх;

ж/эрүүл мэндийн зардалд иргэнээс гарах хувийн төлбөр болон Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний улмаас гадаад улсад эмчилгээ хийлгэхтэй холбоотой өрхийн санхүүгийн дарамтыг бууруулах бодлогын шийдлийг боловсруулах;

з/Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт олгох шаардлагатай эмийн нэр, төрөл, хүртээмжийг бодит хэрэгцээнд нийцүүлэн нэмэгдүүлж, даатгуулагчаас гарах эмийн зардлыг бууруулах бодлогыг үе шаттай хэрэгжүүлэх;

и/Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг сонгох, хамтран ажиллах гэрээ байгуулахдаа тухайн байгууллагын менежмент, нийгмийн хариуцлага, хүний нөөцийн чадавх, дэд бүтэц, санхүүгийн үр ашиг, төсөв, хөрөнгө оруулалтын боломж зэргийг харгалзан үздэг байх шалгуур, стандартыг баталж, мөрдүүлэх;

к/эрүүл мэндийн салбарт хүний хувийн мэдээллийг хамгаалах асуудал, биометрик мэдээллийн талаарх Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах;

л/Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 100 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/130, А/58 дугаар хамтарсан тушаалд заасны дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавих шаардлагыг хангасан эсэхэд үнэлгээ хийж, шаардлагад нийцүүлэх, эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх;

м/эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтны цалин хөлс, ажлын нөхцөлийг санхүүжилтийн шинэчлэл, ажлын гүйцэтгэл, үйлчилгээний чанар, хүний нөөцийн бодлоготой уялдуулан цогцоор нь сайжруулах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулах.

**3/Шүүх шинжилгээ ба хүний эрхийн талаар:**

а/Шүүх шинжилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, хүний эрх, эрх чөлөөг зөрчих эрсдэлтэй шүүх шинжилгээний тодорхой төрлийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах;

б/шүүх шинжилгээний байгууллагаас хийх шинжилгээний арга зүйн зааврыг шинжилгээний төрөл тус бүрээр үндэсний стандарт болгон боловсруулж, баталгаажуулах;

в/хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээ, цогцост шинжилгээ хийх үеийн дуу-дүрсний бичлэг, шинжилгээний обьектыг хадгалах, ашиглах, архивлах, устгах журмыг баталж, мөрдүүлэх;

г/шүүх анагаах ухааны шинжилгээний лаборатори, бүсийн төв болон аймаг, дүүргийн шүүх шинжилгээний нэгжийг стандартын шаардлага хангасан байртай болгох, техник, тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэж, шинжилгээний төрөл, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;

д/алба хаагчдын ажлын ачаалал, шинжилгээний төрөл, үйл ажиллагааны онцлогийг харгалзан орон тоог нэмэгдүүлэх, нийгэм, эдийн засгийн баталгааг тэдний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн сайжруулах, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.

**4/Олон нийтийн мэдэх эрхийн төлөв байдлын талаар:**

а/Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар тогтоосон мэдээллийн төрөл, зааг, ялгаа, агуулгын онцлогийг тодорхой болгож, хууль хоорондын уялдаа холбоог хангах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах;

б/мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хязгаарлах зарчим, шалгуурт нийцсэн эсэхийг шалгасны үндсэн дээр мэдээллийг төрийн нууцад хамааруулах, уг ажиллагаанд олон нийтийн оролцоотой, хараат бус хяналтын тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийг төрийн нууцаас гаргах эрх зүйн зохицуулалтыг мэдэх эрхийг хангах суурь зарчимд нийцүүлэн боловсронгуй болгох талаар санал боловсруулах;

в/Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий бие даасан, тогтвортой бүтэц (зөвлөл)-ийн эрх зүйн үндэс, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох болон мэдээлэл авах хүсэлтэд хариу өгөх, мэдээлэл өгөхөөс татгалзсан үндэслэлийг тайлбарлах, шийдвэрийн эрх зүйн үндэслэл, зайлшгүй болон тохирсон байдлыг нотлох, татгалзсан шийдвэрийг шуурхай, үр дүнтэй хянах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах;

г/мэдээлэл өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, мэдээллийг хууль бусаар хязгаарлалттай, хаалттай ангилалд хамааруулсан, мэдээлэл гаргаж өгөх хугацааг үндэслэлгүйгээр хэтрүүлсэн нийтийн мэдээлэл хариуцагчид хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг Зөрчлийн тухай хуульд тусгах асуудлыг судалж, санал боловсруулах;

д/нийтийн мэдээлэл хариуцагчийн нээлттэй мэдээллийн сан, систем болон цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь нийтийн мэдэх эрхийг бодитоор хангах нөхцөлийг бүрдүүлэх.

**5/Хүний эрх хамгаалагчийн эрхийн хэрэгжилтийн талаар:**

а/Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан “Төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн нийтлэг үүрэг”-ийн хэрэгжилтийг хангах асуудлаар шийдвэр гаргах;

б/төрийн байгууллагын дотоод үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журам, сургалтын хөтөлбөрт хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандах, дэмжлэг үзүүлэх, хуульд заасан үүргээ хэрэгжүүлэхэд нь саад учруулахгүй байх үүргийг тусгаж, албан хаагчдын хөдөлмөрийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөө, үнэлгээтэй нь уялдуулах;

в/хүний эрх хамгаалагчид учирсан болон учирч болзошгүй дарамт, заналхийлэл, удаан хугацаанд үргэлжилсэн стрессээс үүдэх сэтгэл зүйн ачааллыг бууруулах, сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэг үзүүлэх үйлчилгээг бий болгох;

г/төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөрт “хүний эрх хамгаалагчийн эрхийг хамгаалах” агуулгыг тусгах.

**6/Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад эрэгтэйчүүдэд тулгамдаж байгаа асуудлын талаар:**

а/гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийн талаарх албан ёсны тодорхойлолт гаргаж, бүртгэлжүүлэх, тэдэнд чиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлэх;

б/Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022–2031)-нд бүх төрлийн донтолтыг бууруулах болон ганц бие малчин эрэгтэйчүүдэд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх зорилтот арга хэмжээг тусган, үе шаттайгаар хэрэгжүүлэх;

в/“сургуульд хамрагдаагүй”, “сургуулиас гадуур”, “огт суралцаагүй”, “сургууль завсардсан” зэрэг нэр томьёог нэг мөр болгож салбар дундын мэдээллийн нэгдсэн санг бий болгох, сургууль завсардалт, сургалтын хоцрогдлыг эрт илрүүлэх, бууруулах, суурь шалтгааныг арилгахад чиглэсэн зорилтот хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

г/сэргээн засах тусламж, үйлчилгээний хүний нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, донтох эмгэгийг даван туулагчдыг зөвлөгч болгон бэлтгэж, ажиллуулах тогтолцоог бүрдүүлэх, аймаг, сум, дүүрэгт нийгэм, хамт олонд түшиглэсэн сэтгэцийн болон донтох эмгэгийн сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

д/хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэхтэй холбоотой аюулгүй ажиллагааны тусгай журам, стандарт, техникийн зохицуулалтыг боловсруулан баталж, мөрдүүлэх;

е/хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартуудын давхардал, хийдлийг арилгаж, нэгдсэн бүртгэл, ангиллыг шинэчлэх, техникийн зохицуулалтыг батлах;

ё/амиа хорлох оролдлогыг бууруулах, урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх.

2.Энэ тогтоолын 1-д заасан хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг тооцох шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг хавсралтаар баталсугай.

3.Энэ тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тогтоолын хавсралтаар баталсан хэрэгжилтийг тооцох шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнд нийцүүлэн суурь түвшин болон хүрэх түвшингийн хамт баталж, Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд ирүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай.

4.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас баталсан 2019 оны 62, 2021 оны 67, 2022 оны 49, 2023 оны 35, 2024 оны 37, 2025 оны 77 дугаар тогтоолын хэрэгжилтэд давтан хяналт тавих, хэрэгжээгүй шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай.

5.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын болон гишүүний зөвлөмж, шаардлагыг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих, хэрэгжүүлээгүй төрийн байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох саналаа боловсруулж Монгол Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс /Д.Сүнжид/-т тус тус даалгасугай.

6.Энэ тогтоолын хэрэгжилтийг Монгол Улсын Их Хурлын 2027 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай.

7.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ**

Монгол Улсын Их Хурлын 2026 оны
25 дугаар тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 25 ДАХЬ ИЛТГЭЛИЙГ ХЭЛЭЛЦСЭНТЭЙ ХОЛБОГДУУЛАН ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХ, ХАМГААЛАХ, ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТООЦОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН**

| Улсын Их Хурлын тогтоолын дэд заалт | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|
| **1/Хүүхэд хамгааллын тогтолцооны талаар анхаарах зарим асуудлаар:** | | | | |
| 1.1/а | үе тэнгийн болон цахим орчны дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүний хор нөлөөг арилгах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал боловсруулах, хүний нөөц, ур чадвар, холбогдох салбар дундын зохион байгуулалт, уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах; | Судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар боловсруулсан санал | Саналын тоо | Үе тэнгийн болон цахим орчны дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хор нөлөөг бууруулах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох нөхцөл бүрдэж, холбогдох байгууллагын хамтын ажиллагаа, хүний нөөцийн чадавх, салбар дундын уялдаа холбоо сайжирч, үе тэнгийн болон цахим орчны дээрэлхэлт буурсан байна. |
| | | Салбар дундын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ | Арга хэмжээний тоо | |
| 1.1/б | хүүхдийг мансуурах болон сэтгэцэд нөлөөт бодист автахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны үр дүнг үнэлж, танилцуулах; | Үр дүнд үнэлгээ хийж, танилцуулсан баримт бичиг | Танилцуулсан баримт бичгийн тоо | Хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөг нэмэгдүүлэх бодлогын шийдвэр гаргах үндэслэл бүрдсэн байна. |
| 1.1/в | хүүхэд хамгааллын үндэсний тогтолцооны бүрэлдэхүүн хэсэгт хамаарах бүтэц, нэгж тус бүрийн хуулиар хүлээсэн чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлын хэмжээг тэдний бодит хэрэгцээ, үйлчилгээний хүртээмжтэй уялдуулан тогтоож, санхүүжилтийг шийдвэрлэх асуудлаар санал боловсруулах; | Санхүүжилтийн хэрэгцээ, зардлын тооцоонд үндэслэн боловсруулсан санал | Саналын тоо | Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгч бүтэц, нэгжийн бодит хэрэгцээ, үйлчилгээний хүртээмжид үндэслэсэн санхүүжилтийн тооцоо, санал боловсруулж, бодлого, төсөвт тусгах үндэслэл бүрдсэн байна. |
| 1.1/г | шинээр томилогдсон болон ажиллаж байгаа албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, чиг үүргийн онцлогт нийцсэн чадавхжуулах болон давтан сургалтыг тогтмол зохион байгуулах; | Зохион байгуулсан чадавхжуулах болон давтан сургалт | Сургалтын тоо | Албан хаагчдын чиг үүргээ хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвар, хариуцлага сайжирсан байна. |
| | | Сургалтад хамрагдсан албан хаагч | Хамрагдсан албан хаагчийн тоо | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.1/д | хүүхэд хамгааллын чиглэлээр иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах хүрээг нэмэгдүүлэх, төрийн чиг үүргийг тэдгээр байгууллагаар гүйцэтгүүлж байгаа тохиолдолд хүүхэд хамгааллын үйлчилгээний хувьсах зардлыг олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжид хэрхэн тусгах санал боловсруулах; | Хамтын ажиллагаа болон үйлчилгээний санхүүжилтийн талаар боловсруулсан санал | Саналын тоо | Иргэний нийгмийн байгууллагын оролцоо, хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нөхцөл бүрдсэн байна. |
| 1.1/е | хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн орчин, нөхцөлийг хүүхдийн ялгаатай хэрэгцээ болон тэдний онцлог байдалд нийцүүлэн сайжруулах; | Стандартын шаардлагад нийцүүлэн сайжруулсан түр хамгаалах болон нэг цэгийн үйлчилгээний төвийн байр | Байрны тоо | Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн орчин, нөхцөл стандарт шаардлага болон хүүхдийн хэрэгцээнд нийцсэн байна. |
| | | Түр хамгаалах болон нэг цэгийн үйлчилгээний төвийн байрыг стандартын шаардлагад нийцүүлэн сайжруулсан байдал | Хэрэгжилтийн хувь | |
| 1.1/ё | нэг цэгийн үйлчилгээний төвийн стандарт болон Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан холбогдох дүрэм, журам, бусад эрх зүйн баримт бичгийг батлах; | Баталсан эрх зүйн баримт бичиг | Баталсан баримт бичгийн тоо | Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт бүрдэж, хуулийн хэрэгжилтийг хангах нөхцөл бүрдсэн байна. |
| 1.1/ж | хүүхэд хамгааллын үндэсний тогтолцооны бүрэлдэхүүн хэсэгт хамаарах бүтэц, нэгж тус бүрийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тэдний хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, дотоод хяналтын механизмыг боловсронгуй болгох, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хариу арга хэмжээг шуурхай авах тогтолцоог бүрдүүлэх; | Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан | Тайлангийн тоо | Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хариу арга хэмжээ авах тогтолцоо бүрдсэн байна. |
| | | Илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.1/з | хүүхдийн төлөө сангийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа төсөл, арга хэмжээний ач холбогдол, үр нөлөөний байдалд дүн шинжилгээ хийж, уг дүн шинжилгээний үр дүнд үндэслэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу төсөл, арга хэмжээ, санхүүжилтийн хэмжээг тогтоох, зарцуулалтын нээлттэй, ил тод байдлыг хангах зохицуулалтын хэрэгжилтийг сайжруулах; | Санхүүжилтийн үр нөлөөнд хийсэн дүн шинжилгээний тайлан | Тайлангийн тоо | Хүүхдийн төлөө сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний мэдээлэл олон нийтэд нээлттэй, ил тод байдлаар тогтмол мэдээлэгдсэн байна. |
| | | Үнэлгээний үр дүнд үндэслэн санхүүжилтийн шийдвэрт өөрчлөлт оруулсан төсөл, арга хэмжээ | Өөрчлөлт орсон төсөл, арга хэмжээний тоо | |
| | | Нээлттэй, ил тод мэдээлсэн төсөл | Ил тод мэдээлсэн төслийн тоо, хувь | |
| 1.1/и | Хүүхэд хамгааллын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт заасан “Хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн сан”-г бүрдүүлж, ашиглалтад оруулах; | Системийн хөгжүүлэлтийг бүрэн хийж, албан ёсоор ашиглалтад хүлээлгэн өгсөн мэдээллийн нэгдсэн сан | Мэдээллийн системийн тоо | Нэгдсэн мэдээллийн санг тогтмол ашигладаг идэвхтэй хэрэглэгчдийн тоо нэмэгдэж, мэдээллийн системийн бодит ашиглалт хангагдсан байна. |
| | | Нэгдсэн мэдээллийн санд холбогдсон байгууллага | Байгууллагын тоо | |
| | | Хэрэглэгчийн ашиглалтын түвшин (сар бүрийн идэвхтэй хэрэглэгч) | Идэвхтэй хэрэглэгчийн тоо | |
| 1.1/к | Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах гэрээнд хүүхдийн оролцоонд үндэслэн хүүхэд хамгааллын төлөвлөгөө боловсруулж, батлан хэрэгжүүлэх, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангах механизмыг бүрдүүлэх зохицуулалтыг тусгах; | Гэрээнд туссан заалт | Заалтын тоо | Аймаг, нийслэлийн Засаг дарга болон Монгол Улсын Ерөнхий сайдын хооронд байгуулах гэрээнд хүүхдийн эрхийг хамгаалах, нөхцөл байдлыг сайжруулах, хамтын ажиллагаа болон хүүхдийн оролцоог хангах зохицуулалт бүрэн тусгагдаж, хэрэгжилт хангагдсан байна. |
| | | Гэрээнд туссан заалтын хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.1/л | аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд хүүхдэд ээлтэй, аюулгүй орчны үнэлгээг тогтмол хийж, уг үнэлгээг хийхдээ хүүхдийн оролцоог хангах, үнэлгээний үр дүнд үндэслэн эрсдэлийн түвшингээр эрэмбэлсэн хүүхдэд ээлтэй, аюулгүй орчныг бүрдүүлэх чиглэлээр аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах, хэрэгжүүлэх арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулан зохих журмын дагуу батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих; | Хүүхдийн оролцоотой хийсэн үнэлгээ | Үнэлгээний тоо | Хүүхдийн оролцоотой хүүхдэд ээлтэй, аюулгүй орчны үнэлгээ тогтмол хийгдсэн байна. |
| | | Эрсдэлийн үнэлгээнд үндэслэн баталж хэрэгжүүлсэн хүүхдэд ээлтэй орчны арга хэмжээ | Арга хэмжээний тоо | Эрсдэлийн үнэлгээнд үндэслэсэн хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх арга хэмжээ хэрэгжсэн байна. |
| | | Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь | Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт хангагдаж, хүүхдэд ээлтэй орчны нөхцөл сайжирсан байна. |
| 1.1/м | аймаг, нийслэлийн хэмжээнд эрсдэлт нөхцөлд байгаа болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хичээлээс гадуурх сургалт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх арга хэмжээ, нийгмийн оролцооны хөтөлбөрт тогтмол хамруулах бодлого хэрэгжүүлэх; | Зохион байгуулсан сургалт, арга хэмжээ, хөтөлбөр | Сургалт, арга хэмжээ, хөтөлбөрийн тоо | Зорилтот бүлгийн хүүхдүүд хөгжлийн болон нийгмийн оролцооны хөтөлбөрт тогтмол хамрагдаж, тэдний хөгжих, оролцох боломж нэмэгдсэн байна. |
| | | Хөтөлбөрт тогтмол хамрагдсан хүүхэд | Хамрагдалтын хувь | |
| 1.1/н | хүүхэд хамгааллын салбарт ажиллаж байгаа ажилтнуудын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, ажлаас халшрах хам шинжээс урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх. | Бодлогын хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь | Ажилтнуудын сэтгэцийн эрүүл мэнд хамгаалагдаж, ажлын ачааллтай холбоотой халшрах хам шинж буурсан байна. |
| **2/Иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхийн хэрэгжилтийн талаар:** | | | | |
| 1.2/а | эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд үндэслэн эрүүл мэндийн салбарын стандарт, захиргааны хэм хэмжээний актыг шинэчлэх, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтны эрх зүйн байдлыг тодорхойлох болон шинээр нэвтрүүлж байгаа сувилахуйн болон асрахуйн мэргэшсэн тусламж, үйлчилгээтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах; | Шинээр болон нэмэлт өөрчлөлт оруулан баталсан захиргааны хэм хэмжээний акт | Баталсан баримт бичгийн тоо | Эрүүл мэндийн салбарын эрх зүйн зохицуулалт шинэчлэгдэж, захиргааны хэм хэмжээний актууд батлагдсан байна. |
| | | Боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөл | Хуулийн төслийн тоо | Эрүүл мэндийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинэ үйлчилгээний хэлбэрийг зохицуулах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.2/б | хүний эрүүл мэндэд үзүүлэх үр нөлөө нь шинжлэх ухаанаар нотлогдоогүй мэдээллийг олон нийтийн сүлжээгээр цацаж түгээхийг хориглосон хуулийн зохицуулалтын хэрэгжилтийг сайжруулах, мэргэжлийн бус хүмүүсийн олон нийтийн эрүүл мэндэд хор хохирол учруулахуйц асуудлаар төөрөгдүүлсэн мэдээлэл, зар сурталчилгааг нийтэд түгээхийг хориглох, энэ зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хэрэгжилтэд хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгах санал боловсруулах; | Хяналт, шалгалтын тайлан | Хяналт, шалгалтын тоо | Шинжлэх ухааны үндэслэлгүй эрүүл мэндийн мэдээлэл, төөрөгдүүлсэн сурталчилгаанд тавих хяналт, шалгалт тогтмолжиж, зөрчлийг илрүүлэх, арилгах чадавх сайжирсан байна. |
| | | Боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөл | Хуулийн төслийн тоо | Нийтийн эрүүл мэндийг хамгаалах, төөрөгдүүлсэн мэдээлэл түгээхийг хориглох болон хариуцлагын зохицуулалтыг тусгасан хуулийн төсөл боловсруулагдаж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. |
| 1.2/в | эрүүл мэндийн тогтолцоо, шинжлэх ухааны нотолгоо, эрүүл мэндийн технологийн үнэлгээнд тулгуурлан үндэсний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцыг шинээр тодорхойлох; | Шинэчлэн баталсан тусламж, үйлчилгээний багц | Баталсан багцын тоо | Шинжлэх ухааны нотолгоо болон эрүүл мэндийн технологийн үнэлгээнд тулгуурлан шинэчлэгдсэн тусламж, үйлчилгээний багц батлагдсан байна. |
| 1.2/г | нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг салбарын тэргүүлэх чиглэл болгож, санхүүжилтийг үе шаттайгаар нэмэгдүүлэх санал боловсруулах, салбар дундын бодлогыг уялдуулах; | Боловсруулсан санал | Саналын тоо | Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх, салбар дундын бодлогыг уялдуулах нөхцөл бүрдсэн байна. |
| | | Салбар дундын бодлогыг сайжруулах чиглэлээр авсан арга хэмжээ | Арга хэмжээний тоо | Салбар дундын хамтын ажиллагаа сайжирч, бодлогын уялдаа, хэрэгжилтийн үр дүн нэмэгдсэн байна. |
| 1.2/д | төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад зайлшгүй шаардлагатай эмийн нөөцийн хангалтыг нэмэгдүүлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хяналт, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх; | Шаардлагатай эмийн тасалдалгүй хангалтын түвшин | Тасалдалгүй хангалтын хувь | Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын зайлшгүй шаардлагатай эмийн тасалдалгүй хангалт сайжирсан байна. |
| | | Чанар, хяналт хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | Арга хэмжээний тоо | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хяналт, хариуцлагын тогтолцоо бэхэжсэн байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.2/е | эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг алслагдсан бүс нутагт мэдээллийн технологи, харилцаа холбооны хэрэгслийг ашиглан зайнаас үзүүлэх болон хөдөлгөөнт үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, “хүн төвтэй” нэгдмэл тусламж, үйлчилгээг хөгжүүлэх, яаралтай түргэн тусламжийн дуудлагын бүртгэл, мэдээллийг сайжруулж, хуурамч дуудлагаас үүдэлтэй хохирлыг нөхөн төлүүлэх механизмыг нэвтрүүлэх; | Алслагдсан бүсэд хүрсэн зайны болон хөдөлгөөнт тусламж, үйлчилгээнд хамрагдсан хүн | Хамрагдсан хүний тоо | Алслагдсан бүс нутгийн иргэдийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна. |
| | | Анхан шатны тусламж, үйлчилгээг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ | Арга хэмжээний тоо | Хүн төвтэй, нэгдмэл анхан шатны тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан байна. |
| | | Механизмыг нэвтрүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ | Арга хэмжээний тоо | Яаралтай түргэн тусламжийн дуудлагын бүртгэл, хяналтын тогтолцоо сайжирч, хуурамч дуудлагад хариуцлага тооцох механизм нэвтэрсэн байна. |
| 1.2/ё | үйлчлүүлэгчийн хувийн мэдээллийг хамгаалах, нэр төр, алдар хүнд халдашгүй байх эрхийг хангах, мэдээлэл авах болон шийдвэр гаргахад оролцох эрхийг баталгаажуулах, халдварт өвчний шалтгаант ялгаварлан гадуурхалтыг бууруулах, гомдлыг үр дүнтэй шийдвэрлэх механизмыг бэхжүүлэх; | Үйлчлүүлэгчийн хувийн мэдээллийн нууцлал, хүний эрхийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ | Хяналт шалгалтын тоо | Үйлчлүүлэгчийн хувийн мэдээлэл, хүний эрхийг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирсан байна. |
| | | Хяналт шинжилгээний үр дүнд үндэслэн хэрэгжилтийг сайжруулахаар авсан арга хэмжээ | Арга хэмжээний тоо | Хяналт шинжилгээний мөрөөр зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ хэрэгжсэн байна. |
| | | Өвчний шалтгаант ялгаварлан гадуурхалтыг бууруулах, гомдлыг үр дүнтэй шийдвэрлэх чиглэлээр авсан арга хэмжээ | Арга хэмжээний тоо | Халдварт өвчний шалтгаант ялгаварлан гадуурхалт буурч, үйлчлүүлэгчийн эрх хамгаалагдсан байна. |
| | | Гомдол шийдвэрлэлт | Шийдвэрлэсэн гомдлын хувь | Үйлчлүүлэгчийн гомдлыг шуурхай, үр дүнтэй шийдвэрлэх тогтолцоо сайжирсан байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.2/ж | эрүүл мэндийн зардалд иргэнээс гарах хувийн төлбөр болон Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний улмаас гадаад улсад эмчилгээ хийлгэхтэй холбоотой өрхийн санхүүгийн дарамтыг бууруулах бодлогын шийдлийг боловсруулах; | Боловсруулсан бодлогын шийдлийн талаарх санал | Саналын тоо | Иргэн, өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой санхүүгийн дарамтыг бууруулах бодлогын шийдлийг боловсруулсан байна. |
| 1.2/з | Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт олгох шаардлагатай эмийн нэр, төрөл, хүртээмжийг бодит хэрэгцээнд нийцүүлэн нэмэгдүүлж, даатгуулагчаас гарах эмийн зардлыг бууруулах бодлогыг үе шаттай хэрэгжүүлэх; | Хөнгөлөлттэй эмийн нэр төрөл, чанар, хүртээмж нэмэгдсэн түвшин | Нэр төрлийн тоо, чанар, хүртээмжийн хувь | Эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөх эмийн нэр төрөл, хүртээмж нэмэгдэж, даатгуулагчийн эмийн хүртээмж сайжирсан байна. |
| | | Даатгуулагчаас гарах эмийн зардлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ | Арга хэмжээний тоо | Даатгуулагчаас гарах эмийн зардал буурч, эмийн санхүүгийн ачаалал багассан байна. |
| | | Даатгуулагчаас гарах эмийн зардлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь | |
| 1.2/и | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг сонгох, хамтран ажиллах гэрээ байгуулахдаа тухайн байгууллагын менежмент, нийгмийн хариуцлага, хүний нөөцийн чадавх, дэд бүтэц, санхүүгийн үр ашиг, төсөв, хөрөнгө оруулалтын боломж зэргийг харгалзан үздэг байх шалгуур, стандартыг баталж, мөрдүүлэх; | Баталсан эрх зүйн баримт бичиг | Баталсан баримт бичгийн тоо | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг сонгох шалгуур, стандартын хэрэгжилт сайжирч, байгууллагын менежмент, чанар, хариуцлагад суурилсан сонгон шалгаруулалтын тогтолцоо бүрдсэн байна. |
| | | Баталсан эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь | |
| 1.2/к | эрүүл мэндийн салбарт хүний хувийн мэдээллийг хамгаалах асуудал, биометрик мэдээллийн талаарх Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах; | Боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөл | Хуулийн төслийн тоо | Эрүүл мэндийн салбар дахь хүний хувийн болон биометрик мэдээллийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хуулийн төсөл боловсруулагдаж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.2/л | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 100 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/130, А/58 дугаар хамтарсан тушаалд заасны дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавих шаардлагыг хангасан эсэхэд үнэлгээ хийж, шаардлагад нийцүүлэх, эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх; | Хийсэн үнэлгээ | Үнэлгээний тоо | Эрүүл мэндийн мэдээллийн системийн зөрчлийг илрүүлэн арилгаж, стандартын хэрэгжилт сайжирч, нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх ажил эрчимжсэн байна. |
| | | Арилгасан зөрчил | Арилгасан зөрчлийн төрөл, тоо | |
| | | Нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ | Арга хэмжээний тоо | |
| 1.2/м | эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтны цалин хөлс, ажлын нөхцөлийг санхүүжилтийн шинэчлэл, ажлын гүйцэтгэл, үйлчилгээний чанар, хүний нөөцийн бодлоготой уялдуулан цогцоор нь сайжруулах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулах. | Эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлс, ажлын нөхцөл, ачааллыг тэнцвэржүүлэх чиглэлээр боловсруулсан бодлого | Боловсруулсан бодлогын баримт бичгийн тоо | Эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлс, ажлын нөхцөл, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, гүйцэтгэл болон үйлчилгээний чанарт суурилсан хүний нөөцийн бодлого боловсруулагдсан байна. |
| **3/Шүүх шинжилгээ ба хүний эрхийн талаар:** | | | | |
| 1.3/а | Шүүх шинжилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, хүний эрх, эрх чөлөөг зөрчих эрсдэлтэй шүүх шинжилгээний тодорхой төрлийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах; | Хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан | Үнэлгээний тайлангийн тоо | Шүүх шинжилгээний тухай хуулийн хэрэгжилт, хүний эрхэд үзүүлж буй нөлөөллийг үнэлсэн дүн шинжилгээ хийгдсэн байна. |
| | | Боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөл | Хуулийн төслийн тоо | Шүүх шинжилгээний үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хуулийн төсөл боловсруулагдаж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. |
| 1.3/б | шүүх шинжилгээний байгууллагаас хийх шинжилгээний арга зүйн зааврыг шинжилгээний төрөл тус бүрээр үндэсний стандарт болгон боловсруулж, баталгаажуулах; | Баталсан стандарт | Баталсан стандартын тоо | Шүүх шинжилгээний арга зүйн нэгдсэн стандарт боловсруулж, мөрдсөнөөр шинжилгээний чанар, арга зүйн нэгдмэл байдал сайжирсан байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.3/в | хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээ, цогцост шинжилгээ хийх үеийн дуу-дүрсний бичлэг, шинжилгээний обьектыг хадгалах, ашиглах, архивлах, устгах журмыг баталж, мөрдүүлэх; | Баталж, мөрдүүлсэн журам | Баталсан журмын тоо | Шинжилгээний үйл ажиллагаанд дуу-дүрсний бичлэг болон шинжилгээний объектыг хадгалах, ашиглах, архивлах, устгах үйл ажиллагаанд нэгдсэн журам мөрдөгдөж, хүний эрхийн баталгаа хангагдаж, нотлох баримтын хамгаалалт сайжирсан байна. |
| 1.3/г | шүүх анагаах ухааны шинжилгээний лаборатори, бүсийн төв болон аймаг, дүүргийн шүүх шинжилгээний нэгжийг стандартын шаардлага хангасан байртай болгох, техник, тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэж, шинжилгээний төрөл, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх; | Стандартын шаардлага хангасан байр | Байрны тоо | Шүүх шинжилгээний байгууллагын орчин, нөхцөл стандартын шаардлагад нийцэж, орон нутаг дахь үйлчилгээний хүртээмж сайжирсан байна. |
| | | Лаборатори, тоног төхөөрөмжийн шинэчлэл | Хувь | Шүүх шинжилгээний лаборатори, техник, тоног төхөөрөмжийн чадавх сайжирч, шинжилгээний төрөл, чанар, хүртээмж, шуурхай байдал нэмэгдсэн байна. |
| 1.3/д | алба хаагчдын ажлын ачаалал, шинжилгээний төрөл, үйл ажиллагааны онцлогийг харгалзан орон тоог нэмэгдүүлэх, нийгэм, эдийн засгийн баталгааг тэдний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн сайжруулах, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх. | Ажлын байрны зураг авалт, чиг үүргийн шинжилгээ хийсэн тайлан | Тайлангийн тоо | Алба хаагчдын ажлын ачаалал, чиг үүрэгт суурилсан хүний нөөцийн хэрэгцээ тодорхой болж, орон тооны төлөвлөлт сайжирсан байна. |
| | | Боловсруулж, баталсан хөтөлбөр | Баталсан хөтөлбөрийн тоо | Алба хаагчдын нийгэм, эдийн засгийн баталгаа, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах цогц хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн байна. |
| **4/Олон нийтийн мэдэх эрхийн төлөв байдлын талаар:** | | | | |
| 1.4/а | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар тогтоосон мэдээллийн төрөл, зааг, ялгаа, агуулгын онцлогийг тодорхой болгож, хууль хоорондын уялдаа холбоог хангах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах; | Судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн боловсруулсан хуулийн төсөл | Хуулийн төслийн тоо | Мэдээллийн ангилал болон эрх зүйн зохицуулалтын уялдаа, тодорхой байдал сайжрах нөхцөл бүрдсэн байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.4/б | мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хязгаарлах зарчим, шалгуурт нийцсэн эсэхийг шалгасны үндсэн дээр мэдээллийг төрийн нууцад хамааруулах, уг ажиллагаанд олон нийтийн оролцоотой, хараат бус хяналтын тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийг төрийн нууцаас гаргах эрх зүйн зохицуулалтыг мэдэх эрхийг хангах суурь зарчимд нийцүүлэн боловсронгуй болгох талаар санал боловсруулах; | Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар боловсруулсан санал | Саналын тоо | Мэдээллийг төрийн нууцад хамааруулах болон төрийн нууцаас гаргах эрх зүйн зохицуулалтын ил тод, үндэслэлтэй байдал сайжирч, мэдээлэл авах эрхийн баталгаа бэхэжсэн байна. |
| 1.4/в | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий бие даасан, тогтвортой бүтэц (зөвлөл)-ийн эрх зүйн үндэс, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох болон мэдээлэл авах хүсэлтэд хариу өгөх, мэдээлэл өгөхөөс татгалзсан үндэслэлийг тайлбарлах, шийдвэрийн эрх зүйн үндэслэл, зайлшгүй болон тохирсон байдлыг нотлох, татгалзсан шийдвэрийг шуурхай, үр дүнтэй хянах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах; | Боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөл | Хуулийн төслийн тоо | Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, хяналтын тогтолцоог сайжруулах нөхцөл бүрдсэн байна. |
| 1.4/г | мэдээлэл өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, мэдээллийг хууль бусаар хязгаарлалттай, хаалттай ангилалд хамааруулсан, мэдээлэл гаргаж өгөх хугацааг үндэслэлгүйгээр хэтрүүлсэн нийтийн мэдээлэл хариуцагчид хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг Зөрчлийн тухай хуульд тусгах асуудлыг судалж, санал боловсруулах; | Судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөл | Хуулийн төслийн тоо | Нийтийн мэдээллийн ил тод байдлыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын эрх зүйн зохицуулалтыг Зөрчлийн тухай хуульд тусгах нөхцөл бүрдсэн байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.4/д | нийтийн мэдээлэл хариуцагчийн нээлттэй мэдээллийн сан, систем болон цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь нийтийн мэдэх эрхийг бодитоор хангах нөхцөлийг бүрдүүлэх. | “Веб контентын хүртээмжийг нэмэгдүүлэх аргачлал (WCAG 2.1 зөвлөмж)”-д нийцүүлсэн нээлттэй мэдээллийн сан, систем | Нийцүүлсэн нээлттэй мэдээллийн сан, системийн тоо | “Веб контентын хүртээмжийг нэмэгдүүлэх аргачлал (WCAG 2.1 зөвлөмж)”-ыг нэвтрүүлж, хэрэгжилтийг үнэлснээр нээлттэй мэдээллийн хүртээмж, ойлгомжтой байдал сайжирч, иргэдийн мэдэх эрхийн хэрэгжилт сайжирсан байна. |
| | | мэдээллийн ил тод байдлыг зөвхөн мэдээлэл нийтэлсэн эсэхээр бус иргэдийн хэрэглээ, мэдээллийн хүртээмж, ойлгомжтой байдлыг харгалзан үнэлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ | Арга хэмжээний тоо | |
| **5/Хүний эрх хамгаалагчийн эрхийн хэрэгжилтийн талаар:** | | | | |
| 1.5/а | Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан “Төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн нийтлэг үүрэг”-ийн хэрэгжилтийг хангах асуудлаар шийдвэр гаргах; | Хуулийн хэрэгжилтийг хангах асуудлаар баталсан Монгол Улсын Засгийн газрын тогтоол | Тогтоолын тоо | Хүний эрх хамгаалагчийн эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн хариуцлагатай байдал сайжирсан байна. |
| | | Монгол Улсын Засгийн газрын тогтоолын хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь | |
| 1.5/б | төрийн байгууллагын дотоод үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журам, сургалтын хөтөлбөрт хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандах, дэмжлэг үзүүлэх, хуульд заасан үүргээ хэрэгжүүлэхэд нь саад учруулахгүй байх үүргийг тусгаж, албан хаагчдын хөдөлмөрийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөө, үнэлгээтэй нь уялдуулах; | Дотоод үйл ажиллагааны дүрэм, журам, сургалтын хөтөлбөрт хуульд заасан шаардлагыг тусгасан байгууллага | Байгууллагын тоо/ эзлэх хувь | Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааг хүндэтгэх, дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчин боловсронгуй болсон байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.5/в | хүний эрх хамгаалагчид учирсан болон учирч болзошгүй дарамт, заналхийлэл, удаан хугацаанд үргэлжилсэн стрессээс үүдэх сэтгэл зүйн ачааллыг бууруулах, сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэг үзүүлэх үйлчилгээг бий болгох; | Сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэг үзүүлэх үйлчилгээ | Үйлчилгээний төрөл | Хүний эрх хамгаалагчийн аюулгүй байдал, сэтгэл зүйн хамгаалалт сайжирч, дэмжлэг авах боломж нэмэгдсэн байна. |
| | | Хүний эрх хамгаалагчийг хамгаалах, дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ | Арга хэмжээний тоо | |
| | | Салбар, орон нутгийн хэмжээнд сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдсан хүний эрх хамгаалагч | Хамрагдсан хүний эрх хамгаалагчийн тоо | |
| 1.5/г | төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөрт “хүний эрх хамгаалагчийн эрхийг хамгаалах” агуулгыг тусгах. | Агуулгыг тусгасан хөтөлбөр | Агуулгын эзлэх хувь | Хүний эрх хамгаалагчийн эрх, үйл ажиллагааг хүндэтгэх хамгаалах мэдлэг, хандлага сайжирсан байна. |
| **6/Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад эрэгтэйчүүдэд тулгамдаж байгаа асуудлын талаар:** | | | | |
| 1.6/а | гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийн талаарх албан ёсны тодорхойлолт гаргаж, бүртгэлжүүлэх, тэдэнд чиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлэх; | Батлагдсан албан ёсны тодорхойлолт, бүртгэлийн журам | Баримт бичгийн тоо | Гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийг албан ёсоор тодорхойлох, бүртгэх тогтолцоо бүрдэж, тэдэнд чиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээний хүртээмж, хамрагдалт сайжирсан байна. |
| | | Гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийн нэгдсэн бүртгэлийн сан | Бүртгэлийн сангийн тоо | |
| | | Бүртгэлд хамрагдсан иргэд | Хамрагдсан иргэдийн тоо | |
| | | Нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдсан иргэд | Хамрагдсан иргэдийн тоо, хувь | |
| | | Гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдэд чиглэсэн нийгмийн хамгааллын хүрээнд үзүүлсэн үйлчилгээ | Үйлчилгээний төрөл, үйлчилгээ үзүүлсэн тоо | |
| | | Нийгэмшүүлэх арга хэмжээнд хамрагдсан иргэд | Хамрагдсан иргэдийн тоо | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.6/б | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022–2031)-нд бүх төрлийн доноолтыг бууруулах болон ганц бие малчин эрэгтэйчүүдэд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх зорилтот арга хэмжээг тусган, үе шаттайгаар хэрэгжүүлэх; | Төлөвлөгөөнд тусгасан зорилтот арга хэмжээ | Арга хэмжээний тоо | Донтолтоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр нөлөө сайжирч, ганц бие малчин эрэгтэйчүүдэд үзүүлэх дэмжлэг, үйлчилгээний хүртээмж нэмэгдэн, жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын бодлогын хэрэгжилт, уялдаа холбоо сайжирсан байна. |
| | | Стратеги төлөвлөгөөнд тусгагдаж хэрэгжүүлсэн зорилтот арга хэмжээ | Арга хэмжээний тоо | |
| | | Зорилтот үйлчилгээний хамрагдалт | Хамрагдсан хүний тоо | |
| | | Зорилтот арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь | |
| 1.6/в | "сургуульд хамрагдаагүй", "сургуулиас гадуур", "огт суралцаагүй", "сургууль завсардсан" зэрэг нэр томьёог нэг мөр болгож салбар дундын мэдээллийн нэгдсэн санг бий болгох, сургууль завсардалт, сургалтын хоцрогдлыг эрт илрүүлэх, бууруулах, суурь шалтгааныг арилгахад чиглэсэн зорилтот хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх; | Сургууль завсардалт, сургалтын хоцрогдлыг бууруулах, суурь шалтгааныг илрүүлэхэд хийсэн судалгаа | Хийсэн судалгааны тоо | Сургууль завсардалт, сургалтын хоцрогдол буурч, сурч боловсрох эрхийн хэрэгжилт сайжирсан байна. |
| | | Боловсруулж, баталсан зорилтот хөтөлбөр | Баталсан хөтөлбөрийн тоо | |
| | | Хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ | Арга хэмжээний тоо | |
| | | Сургуульд хамрагдаагүй, завсардсан хүүхдийн насны бүлэг, хүйс, оршин суугаа газар, хөгжлийн бэрхшээлээр ангилан бүртгэсэн статистик мэдээлэл | Статистик мэдээллийн тоо | |
| | | Ашиглалтад оруулсан салбар дундын мэдээллийн нэгдсэн сан | Мэдээллийн сангийн тоо | |
| | | Сургууль завсардалт, сургалтын хоцрогдлын суурь шалтгааныг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ | Арга хэмжээний тоо, бууралтын хувь | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.6/г | сэргээн засах тусламж, үйлчилгээний хүний нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, донтох эмгэгийг даван туулагчдыг зөвлөгч болгон бэлтгэж, ажиллуулах тогтолцоог бүрдүүлэх, аймаг, сум, дүүрэгт нийгэм, хамт олонд түшиглэсэн сэтгэцийн болон донтох эмгэгийн сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх; | Зөвлөгч болгон бэлтгэсэн сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, даван туулагч | Бэлтгэгдсэн зөвлөгчийн тоо | Нийгэм, хамт олонд түшиглэсэн сэтгэцийн болон донтох эмгэгийн сэргээн засах тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, сэтгэцийн болон донтох эмгэгтэй хүний тоо буурсан байна. |
| | | Боловсруулж, баталсан хөтөлбөр | Баталсан хөтөлбөрийн тоо | |
| | | Баталсан хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ | Арга хэмжээний тоо | |
| | | Сэргээн засах тусламж, үйлчилгээний хүртээмж, хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь | |
| | | Үйлчилгээнд хамрагдсан иргэд | Хамрагдсан хүний тоо | |
| 1.6/д | хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэхтэй холбоотой аюулгүй ажиллагааны тусгай журам, стандарт, техникийн зохицуулалтыг боловсруулан баталж, мөрдүүлэх; | Баталсан журам, стандарт, техникийн зохицуулалт | Баталсан журам, стандарт, техникийн зохицуулалтын тоо | Хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэх аюулгүй ажиллагааны журам, стандарт, техникийн зохицуулалтыг батлан хэрэгжүүлснээр ажилтнуудын аюулгүй байдал хангагдаж, хөдөлмөрийн осол, эрсдэл буурсан байна. |
| | | Баталсан журам, стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь | |
| | | Аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан ажилтан | Хамрагдсан хүний тоо | |
| | | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлын түвшний бууралт | Бууралтын хувь | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.6/е | хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартуудын давхардал, хийдлийг арилгаж, нэгдсэн бүртгэл, ангиллыг шинэчлэх, техникийн зохицуулалтыг батлах; | Баталсан стандарт, журам, техникийн зохицуулалт | Баталсан стандарт, журам, техникийн зохицуулалтын тоо | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын давхардал, хийдлийг арилган шинэчлэн баталж, тэдгээрийг байгууллагуудад үр дүнтэй мөрдүүлснээр стандартын хэрэгжилт сайжирч, ажлын байрны аюулгүй байдал хангагдсан байна. |
| | | Нэгдсэн бүртгэл, ангилал шинэчилсэн байдал | Мэдээллийн нэгдсэн сангийн тоо | |
| | | Баталсан стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь | |
| 1.6/ё | амиа хорлох оролдлогыг бууруулах, урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх. | Амиа хорлох оролдлогыг бууруулах, урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний талаар баталсан төлөвлөгөө | Баталсан төлөвлөгөөний тоо | Амиа хорлох оролдлогоос урьдчилан сэргийлэх цогц төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлснээр сэтгэл зүйн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, амиа хорлох оролдлого болон нас баралтын түвшин буурсан байна. |
| | | Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ | Арга хэмжээний тоо | |
| | | Сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдсан хүн | Хамрагдсан хүний тоо | |
| | | Сэтгэл зүйчээр ажиллах орон тооны өсөлт | Өсөлтийн хувь | |
| | | Амиа хорлох оролдлогын түвшний бууралт | Бууралтын хувь | |
| | | Амиа хорлолтоос шалтгаалсан нас баралтын түвшний бууралт | Бууралтын хувь | |
| | | Урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээнд хамрагдсан иргэд | Иргэдийн тоо | |

---o0o---

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ

᠒᠐᠒᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠒᠓ – ᠤ ᠡᠳᠦᠷ — ᠳᠤᠭᠠᠷ ᠒᠔ — ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

᠓. [illegible]

᠔. [illegible]

᠕. [illegible]

᠖. [illegible]

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠨ.ᠤᠴᠢᠷᠠᠯ

[illegible]

[illegible]

| | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
|---|---|---|---|---|
| [illegible] | | | | |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | [illegible] | |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | [illegible] | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | [illegible] | |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | [illegible] | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |

[illegible]

| | | | | |
|---|---|---|---|---|
| ᠖.᠒.᠖ | ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠤᠨ ᠰᠢᠰᠲ᠋ᠧᠮ ᠳᠦ ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠬᠦ ᠵᠢᠴᠢ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠰᠢᠨᠡᠴᠢᠯᠡᠬᠦ ᠂ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠤᠪᠢᠶᠠᠷᠢᠯᠠᠬᠤ ᠂ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠬᠢᠨᠠᠨ ᠬᠢᠶᠠᠬᠤ ᠂ ᠬᠠᠷᠢᠭᠤ ᠬᠦᠷᠭᠡᠬᠦ ᠃ | ᠰᠢᠨᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠂ ᠬᠠᠰᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ | ᠰᠢᠨᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠂ ᠬᠠᠰᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ | ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠰᠢᠨᠡᠴᠢᠯᠡᠨ ᠬᠤᠪᠢᠶᠠᠷᠢᠯᠠᠬᠤ ᠪᠤᠯᠤᠨ᠎ᠠ ᠄᠄ |
| | | ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠬᠢᠨᠠᠨ ᠬᠢᠶᠠᠬᠤ ᠵᠢᠴᠢ ᠬᠠᠷᠢᠭᠤ ᠬᠦᠷᠭᠡᠬᠦ | ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠬᠢᠨᠠᠬᠤ | ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠬᠢᠨᠠᠨ ᠬᠢᠶᠠᠵᠤ ᠂ ᠬᠠᠷᠢᠭᠤ ᠬᠦᠷᠭᠡᠬᠦ ᠪᠤᠯᠤᠨ᠎ᠠ ᠄᠄ |
| ᠖.᠒.᠗ | ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠨᠢᠭᠡᠳᠬᠡᠬᠦ ᠂ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠬᠤᠭᠤᠷᠤᠨᠳᠤ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠰᠤᠯᠢᠯᠴᠠᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠬᠠᠩᠭᠠᠬᠤ ᠄᠄ | ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠰᠤᠯᠢᠯᠴᠠᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ | ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠰᠤᠯᠢᠯᠴᠠᠭ᠎ᠠ | ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠬᠤᠭᠤᠷᠤᠨᠳᠤ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠰᠤᠯᠢᠯᠴᠠᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠬᠠᠩᠭᠠᠬᠤ ᠪᠤᠯᠤᠨ᠎ᠠ ᠄᠄ |
| ᠖.᠒.᠘ | ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭᠤᠯᠬᠤ ᠄᠄ ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭᠤᠯᠵᠤ ᠂ ᠵᠥᠷᠢᠴᠡᠯ ᠢ ᠢᠯᠡᠷᠡᠭᠦᠯᠬᠦ ᠄᠄ | ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭᠤᠯᠬᠤ ᠂ ᠵᠥᠷᠢᠴᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ | ᠵᠥᠷᠢᠴᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ | ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭᠤᠯᠵᠤ ᠂ ᠵᠥᠷᠢᠴᠡᠯ ᠢ ᠢᠯᠡᠷᠡᠭᠦᠯᠬᠦ ᠪᠤᠯᠤᠨ᠎ᠠ ᠄᠄ |

| | | | |
|---|---|---|---|
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | |
| [illegible] | [illegible] | [illegible] | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| | [illegible] | [illegible] | [illegible] | |
| | [illegible] | [illegible] | [illegible] | |
| | [illegible] | [illegible] | [illegible] | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | [illegible] | |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | [illegible] | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | [illegible] | |
| | | [illegible] | [illegible] | |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | | | | |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | [illegible] | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | ᠠᠶᠢᠮᠠᠭ | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | [illegible] | [illegible] |

| | | | | |
|---|---|---|---|---|
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |

| | | | | |
|---|---|---|---|---|
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | [illegible] | |
| [illegible] | | | | |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] «[illegible] (WCAG 2.1 [illegible]) » — [illegible] | [illegible] | [illegible] «[illegible] (WCAG 2.1 [illegible]) » — [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |

| | | | | |
|---|---|---|---|---|
| [illegible] | | | | |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | [illegible] | |
| | | [illegible] | [illegible] | |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 10.6/а | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | [illegible] | |
| | | [illegible] | [illegible] | |
| | | [illegible] | [illegible] | |
| | | [illegible] | [illegible] | |
| | | [illegible] | [illegible] | |
| 10.6/б | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | [illegible] | |
| | | [illegible] | [illegible] | |
| | | [illegible] | [illegible] | |

| | |
|---|---|
| ᠑᠂᠖/᠗ | |
| «ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠴᠢᠶ᠋ᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠶ᠋ᠢ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ»᠂ «ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠴᠢᠶ᠋ᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠶ᠋ᠢ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠬᠤ ᠵᠥᠪᠯᠡᠯ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ»᠂ «ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠴᠢᠶ᠋ᠢᠨ ᠨᠡᠶᠢᠭᠡᠮ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ» ᠵᠡᠷᠭᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ ᠡᠷᠬᠡ ᠪᠦᠬᠦᠢ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠪᠦᠷᠢᠯᠳᠦᠭᠦᠨ ᠦ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠴᠢᠶ᠋ᠢᠨ ᠨᠡᠶᠢᠭᠡᠮ ᠦᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ᠂ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠵᠢᠯᠢᠭ ᠪᠦᠬᠦᠢ ᠠᠵᠢᠯ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠬᠤ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ᠂ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭᠴᠢ ᠪᠤᠶᠤ᠃ | |
| ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠴᠢᠶ᠋ᠢᠨ ᠨᠡᠶᠢᠭᠡᠮ ᠦᠨ᠂ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠴᠢᠳ ᠦᠨ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ ᠤᠨ᠂ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭᠰᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠳᠤᠰᠢᠶᠠᠯ ᠤᠨ | ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠬᠤ ᠶᠢᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ |
| ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ᠂ ᠪᠣᠳᠯᠣᠭᠣ ᠶᠢᠨ ᠳᠤᠰᠢᠶᠠᠯ ᠤᠨ | ᠪᠣᠳᠯᠣᠭᠣ ᠶᠢᠨ ᠳᠤᠰᠢᠶᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ |
| ᠪᠣᠳᠯᠣᠭᠣ ᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ ᠦᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠬᠡᠯᠲᠡᠰ | ᠠᠯᠪᠠᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ ᠦᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ |
| ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠴᠢᠶ᠋ᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠶ᠋ᠢ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠬᠤ᠂ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭᠰᠠᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ ᠦᠨ᠂ ᠪᠠᠢᠴᠠᠭᠠᠬᠤ᠂ ᠬᠢᠨᠠᠬᠤ᠂ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ᠂ ᠠᠵᠢᠯᠯᠠᠭᠠᠨ ᠤ ᠪᠠᠢᠴᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠪᠦᠳᠦᠭᠡᠭᠳᠡᠭᠦᠨ ᠦ ᠠᠯᠪᠠᠨ ᠤ ᠠᠵᠢᠯᠲᠠᠨ ᠤ | ᠠᠵᠢᠯᠲᠠᠨ ᠤ ᠠᠯᠪᠠ ᠶᠢᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ |
| ᠠᠵᠢᠯᠯᠠᠭᠠᠨ ᠤ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠣ ᠶᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠤ ᠠᠵᠢᠯᠲᠠᠨ ᠤ | ᠠᠵᠢᠯᠲᠠᠨ ᠤ ᠠᠯᠪᠠ ᠶᠢᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ |
| ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠴᠢᠶ᠋ᠢᠨ ᠨᠡᠶᠢᠭᠡᠮ ᠦᠨ᠂ ᠪᠠᠢᠴᠠᠭᠠᠬᠤ ᠬᠢᠨᠠᠬᠤ ᠶᠢᠨ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ ᠦᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠤ ᠬᠡᠯᠲᠡᠰ | ᠪᠠᠢᠴᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ ᠦᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ᠂ ᠪᠠᠢᠴᠠᠭᠠᠭᠴᠢ |
| ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠴᠢᠶ᠋ᠢᠨ ᠨᠡᠶᠢᠭᠡᠮ ᠦᠨ᠂ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠴᠢᠳ ᠦᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠪᠦᠲᠦᠴᠡ ᠶᠢᠨ ᠨᠢᠭᠡᠴᠡ ᠪᠠᠢᠨ᠎ᠠ᠃ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| ᠖.᠙/᠑ | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | [illegible] | |
| | | [illegible] | [illegible] | |
| | | [illegible] | [illegible] | |
| | | [illegible] | [illegible] | |
| ᠖.᠙/᠒ | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | [illegible] | |
| | | [illegible] | [illegible] | |
| | | [illegible] | [illegible] | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | [illegible] | |
| | | [illegible] | [illegible] | |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| | | [illegible] | [illegible] | |
| | | [illegible] | [illegible] | |
| | | [illegible] | [illegible] | |
| | | [illegible] | [illegible] | |
| | | [illegible] | [illegible] | |
| | | [illegible] | [illegible] | |

---ooo---

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 52 | Улаанбаатар хот

## Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх” сэдэвт ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай:

1/Малчны тухай хууль, Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль, Газрын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Усны тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн уялдааг хангах талаар санал боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/Малчны тухай хуульд заасан батлагдаагүй дүрэм, журам, аргачлал, төлөвлөгөөг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, мөрдүүлэх;

3/малчдын хөдөлмөрийн үнэлэмж, орлогын тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэ цэнийг өсгөх, чанарт суурилсан бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

4/Малчны тухай хуульд заасан малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх зохицуулалтын хэрэгжилтийг хангах, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

5/малчдын нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дэмжих талаар салбар дундын нэгдсэн арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх;

6/орон сууцны ипотекийн зээлийн хүртээмжийг орон нутагт нэмэгдүүлэх, ипотекийн шалгуур үзүүлэлтийг тогтоохдоо барьцаа хөрөнгийн болон орлогын тогтворгүй байдлыг харгалзан малчдын онцлогт тохирсон зохицуулалтыг бий болгох;

7/мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний зах зээлийн ханшид суурилсан хөрөнгийн үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох;

8/малчинд зориулсан нэн хөнгөлөлттэй, хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, зээлийн эрсдэлийн үнэлгээнд үндэслэн зээлийн хөнгөлөлт үзүүлэх аргачлал боловсруулах талаар Монголбанктай хамтран шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

9/малчдын залгамж халааг бэлтгэхтэй холбогдуулан мал аж ахуйн чиглэлээр суралцагчийн тоог мэргэжлийн чиглэл, индекс, босго онооны хүрээнд судалж, нэмэгдүүлэх арга хэмжээг авах;

10/Малчны хөгжлийн сангийн үйл ажиллагааг эхлүүлэх эрх зүйн болон санхүүгийн нөхцөлийг бүрдүүлэх;

11/хууль хэрэгжүүлэх хүрээнд баталсан захиргааны хэм хэмжээний акт хуульд нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, хуулиар олгоогүй нэмэлт шаардлага тогтоосон, иргэн, хуулийн этгээдийн эрхийг хязгаарласан зохицуулалтыг өөрчлөх, хүчингүй болгох арга хэмжээг авах.

2.Энэ тогтоолын хэрэгжилтийн явцыг Монгол Улсын Их Хурлын 2027 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /М.Мандхай/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ**

[illegible]

᠖/ [illegible]

᠗/ [illegible]

᠘/ [illegible]

᠙/ [illegible]

᠑᠐/ [illegible]

᠑᠑/ [illegible]

᠒. [illegible]

᠓. [illegible]

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠭᠠᠳᠠᠭᠠᠳᠤ ᠬᠡᠷᠡᠭ ᠦᠨ ᠰᠠᠶᠢᠳ [illegible]

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 53 | Улаанбаатар хот

**Засгийн газарт чиглэл өгөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 22.3.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Орон сууц захиалах, худалдан авах асуудлыг зохицуулж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох, энэ хүрээнд үүсэж байгаа зөрчил, маргааныг шийдвэрлэх, хохирсон иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай:

1/орон сууцны борлуулалт болон барилгын үйл ажиллагаанд эрсдэлийг хуваарилах, хөндлөнгийн хяналт тавих, орон сууц захиалж байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах механизмыг бий болгох, орон сууц захиалахад тавих шаардлага, шалгуурыг тодорхойлох чиглэлээр Барилгын тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/орон сууцыг давхардуулан худалдах, захиалга авах эрсдэлийг бууруулах зорилгоор барилгын зөвшөөрөл, газрын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, нотариатын үйл ажиллагаа болон бусад холбогдох салбарын мэдээллийн сангийн уялдааг хангаж, нэгдсэн цахим системийг бий болгон нэвтрүүлэх;

3/орон сууцны барилгын үйл ажиллагаа болон захиалга авч эхлэхээс өмнө тухайн хуулийн этгээдийн санхүүгийн чадавх, хэрэгжүүлсэн төсөл, өр төлбөр, эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл, барилгын ажлын явцын тухай мэдээллийг хууль тогтоомжийн хүрээнд олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх нөхцөлийг бүрдүүлэх;

4/баригдаж дуусаагүй болон удаан хугацаанд зогссон орон сууцны барилгад иж бүрэн үнэлгээ, хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, төслийг үргэлжлүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, техникийн нөхцөл олгох, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх замаар төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;

5/дахин төлөвлөн барилгажуулах төслийг хэрэгжүүлэхэд төрөөс хариуцах инженерийн дэд бүтцийн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлж, зардлыг төсвийн төсөлд тусгах;

6/дахин төлөвлөн барилгажуулах төсөл, орон сууц захиалгын гэрээ, хувьцаат орон сууцны хэлбэрээр хөрөнгө татах болон давхардуулан захиалга авсны улмаас хохирсон иргэдийн гомдлыг нэгтгэн судалж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх ажиллагааг эрчимжүүлж, уг асуудлыг шийдвэрлэж дуусах хүртэл хугацаанд хохирсон иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлын хэсэг байгуулан ажиллуулах;

7/орон сууц захиалгын гэрээтэй холбоотой шүүхийн шийдвэрийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, иргэдэд учирсан хохирлыг барагдуулах ажиллагааг эрчимжүүлэх, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг авах.

2.Энэ тогтоолын хэрэгжилтийг Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо /О.Номинчимэг/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ

[illegible]

[illegible]

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠷᠦᠩᠬᠡᠢᠢᠯᠡᠭᠴᠢ

ᠤ᠂ᠬᠦᠷᠡᠯᠰᠦᠬ

**Хаяг:**
“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn
**Утас:** 262420
Хэвлэлийн хуудас: 7.5
**Индекс: 200003**